



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

**Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний
удирдамж батлах тухай**

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 34.1 дэх заалт болон «Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги»-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

Нэг. Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын зааврыг нэгдүгээр, Эмэнд мэдрэг сүрьеэгийн тусламж, үйлчилгээний удирдамжийг хоёрдугаар, Эмэнд дасалтай сүрьеэгийн тусламж, үйлчилгээний удирдамжийг гуравдугаар, Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдварын тусламж, үйлчилгээний удирдамжийг дөрөвдүгээр, Сүрьеэгийн эм, урвалж бодисын менежментийн удирдамжийг тавдугаар, Сүрьеэгийн тархвар судлал, халдвар хяналтын арга хэмжээний удирдамжийг зургаадугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамжийг долоодугаар, Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааны удирдамжийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх 2-5 ортой 1-2 өрөөг халдвар хяналтын дэглэмийн дагуу батлагдсан төсөвтөө багтаан 2010 оны 1 дүгээр сараас зохион байгуулж, 2011 оноос орон нутгийн төсөвтөө тусган тогтвортой ажиллуулахыг Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Эмэнд дасалтай сүрьеэгийн тасгийг батлагдсан орон тоондоо багтаан халдвар хамгааллын дэглэмийн дагуу 60 ортой болгон 2010 оны 1 дүгээр сараас эхлэн өргөжүүлэн

ажилуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасгай.

Дөрөв. Улаанбаатар хотын орон гэргүй, тэнэмэл, оршин суух тодорхой хаяггүй иргэдэд сүрьеэгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор 2011 оны 1 дүгээр сараас улсын төсөвт тусган Энэрэл эмнэлэгт 16 ор бүхий сүрьеэгийн тасгийг тогтвортой ажиллуулахыг Санхүү хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Ц.Ганхүү) нарт үүрэг болгосугай.


Тав. Сүрьеэгийн эм, урвалж бодис хадгалах өрөөг энэ тушаалын тавдугаар хавсралтын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдлийн дарга нарт үүрэг болгосугай.

Зургаа. Үндэсний хэмжээнд шаардлагатай сүрьеэгийн эм, урвалж бодисыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), хуваарилагдсан эм, урвалж бодис татан авахад зарцуулагдах тээврийн зардлыг хариуцахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга нарт даалгасугай.

Долоо. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ш.Энхбат), Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Энхболд)-г тус тус даалгасугай.

Найм. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2003 оны А/190, 2006 оны 176 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



 С.ЛАМБАА

Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт

Нэг. Халдварт өвчин судлалын үндэсний төв

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь «Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх үндэсний стратеги» -ийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх стандарт, нэгдсэн аргачлал боловсруулах, сургалт зохион байгуулах, сүрьеэгийн өвчлөл, тархалт, нас баралт, эмчилгээний үр дүнг тархвар судлал, лабораторийн шинжилгээний аргаар тандан судлах, эмэнд мэдрэг болон дасалтай сүрьеэгийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөх, сүрьеэгийн эм, урвалж бодисын хэрэгцээг тооцох, захиалах, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, хуваарилах ажлыг хариуцан мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, олон улсын хэмжээнд мөрдөж байгаа «Сүрьеэтэй өвчтөний тусламж үйлчилгээний тунхаг бичиг»-ийн дагуу ажиллана.

Нэг. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдэл

- 1.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн бүтэц орон тоог үйлчлэх хүрээний хүн ам, өвчлөл, тархалтын байдалд үндэслэн сүрьеэгийн зохицуулагч эмч 1, мэргэжлийн 2-5 эмч, сувилагч 2-5, лаборант 1-2 гэсэн бүрэлдэхүүнтэй тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 1.2 Үйлчлэх хүрээний хүн амын сүрьеэгийн өвчлөлийн түвшин, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын байдалд хагас, бүтэн жилээр үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээг төлөвлөж, сүрьеэгийн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
- 1.3 Сүрьеэгийн эм, лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисын санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгана.
- 1.4 Сүрьеэгийн эм хадгалах өрөөг стандартын дагуу зохион байгуулна.

-
- 1.5 Сүрьеэгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх зорилгоор өрхийн эмнэлэгт хийгдэж байгаа үргэлжлэх шатны эмчилгээнд хяналт тавина.
 - 1.6 Сүрьеэгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор сорьц тээвэрлэх тогтолцоог бэхжүүлэх, бичил харуурын шинжилгээний хамралтыг өргөжүүлнэ.
 - 1.7 Сүрьеэгийн нэгж байгууллагын эмч, мэргэжилтнийг ажлын байрны аюулгүй ажиллагаа, халдвар хяналтын нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
 - 1.8 Сүрьеэгийн хавьтлын судалгаа, үзлэг шинжилгээг аймгуудад дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч, нийслэлд эрүүл мэндийн нэгдлийн халдвар судлагч, сүрьеэгийн диспансерийн эмчтэй хамтран хийнэ.
 - 1.9 Мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх, орон нутагт тулгарч буй асуудлыг удирдах дээд шатны байгууллагад санал оруулж шийдвэрлүүлнэ.

Хоёр. Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер

- 2.1 Орон нутагт сүрьеэгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулахад тэргүүлэх үүрэгтэй оролцоно.
- 2.2 Сүрьеэгийн зохицуулагч эмч нь сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажлыг хариуцан, орон нутгийн засаг захиргаа, эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагч нартай хамтран, сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.3 Орон нутаг дахь сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагаанд хамтран оролцогч байгууллага, өрх, сумын эмч, мэргэжилтэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- 2.4 Сүрьеэгийн эмнэлэг, тасаг, диспансерийн эмч, мэргэжилтний ажлын байрны аюулгүй ажиллагаа, халдвар хяналтын дэглэм, зааврыг чанд мөрдөн, дотоод хяналт тавьж ажиллана.
- 2.5 Сүрьеэгийн оношлогоо, эмчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, урвалж бодис, эмийг захиалах, хадгалах, хуваарилах арга хэмжээ авч, зарцуулалтанд хяналт тавина.
- 2.6 Сүрьеэгийн сэжигтэй, шинэ, давтан бүртгэгдсэн сүрьеэтэй өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэн оношлох, шууд

хяналттай эмчлэх, эмэнд мэдрэг, дасалтай сүрьеэтэй өвчтөний хавьтлын судалгааг халдвар судлагч, сум, өрхийн эмчтэй хамтран хийж, үзлэг шинжилгээнд хамруулна.

- 2.7 Үйлчлүүлэгчийг аль шатлалын эрүүл мэндийн байгууллага (тасаг, сум, өрхийн эмнэлэг, өдрийн эмчилгээний цэг, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн)-д шууд хяналттай эмчлэхийг шийдвэрлэж, эмчилгээний явцын хяналтын шинжилгээг товлосон хугацаанд нь хийлгэн, хөдөлмөрийн чадвар түр алдалтын асуудлыг зохицуулна.
- 2.8 Жирэмсэн, төрсний дараах үеийн сүрьеэг эрт илрүүлэх, эмчлэх, хяналт тогтоох арга хэмжээг анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.9 Сүрьеэг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар ухуулга, мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.
- 2.10 Сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад цаг хугацаанд нь илгээнэ.

Гурав. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд

- 3.1 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчээс цэрний сорьц авч өөрийн лабораторид шинжлэн оношийг тогтоох, цэрний түрхэцийн шинжилгээ хийх боломжгүй үед үйлчлүүлэгч эсвэл сорьцыг харьяа дүүргийн сүрьеэгийн диспансерт, хөдөө орон нутгийн үйлчлүүлэгч эсвэл сорьцыг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээж онош баталгаажуулна.
- 3.2 Уушгины түрхэц сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэгийн онош эргэлзээтэй тохиолдолд ХӨСҮТ-өөс эмч дуудан зөвлөгөө авч онош тодруулна.

Дөрөв. Амаржих газар

- 4.1 Нярайн эмч БЦЖ вакцин тарихад хориглох заалт байгаа эсэхийг нягтлан, нярайг төрсний дараа 24 цагийн дотор сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцинаар дархлаажуулах талаар дүгнэлт гаргана.
- 4.2 Тусгай бэлтгэгдсэн сувилагч БЦЖ вакциныг хийж, дархлаажуулсан тухай эрүүл мэндийн дэвтэр буюу солилцох хуудсанд, вакцин хийгдээгүй бол шалтгааныг тодорхой тэмдэглэнэ.
- 4.3 Амаржих газрын халдвар судлагч вакцин хийх арга техник,

БЦЖ вакцины хадгалалтанд хяналт тавьж, вакцины төлөвлөлт, захиалга, хадгалалт, тээвэрлэлт, аюулгүй дархлаажуулалтын заавар, журмыг мөрдөж ажиллана.

**Тав. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд
(сум, өрхийн эмнэлэг)**

- 5.1 Үйлчлэх хүрээний хүн амын дунд сүрьеэд өртөх эрсдэл өндөртэй бүлгийн хүмүүсийн судалгаа гарган, холбогдох байгууллагатай хамтран идэвхитэй, хагас идэвхитэй үзлэг зохион байгуулна.
- 5.2 Нярайд хийсэн БЦЖ вакцины урвал хүндрэл, сорвижилтыг 1, 3, 12 сартайд нь үнэлэн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хэрэв сорви үүсээгүй бол туберкулины сорил тавьж сөрөг тохиолдолд нөхөн дархлаажуулалтад хамруулна.
- 5.3 Төрсний дараа БЦЖ вакцинд хамрагдаагүй хүүхдийг харъяа эрүүл мэндийн байгууллагын хүүхэд, сүрьеэ, дархлаажуулалтын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран нөхөн дархлаажуулалтанд хамруулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.4 Үйлчлэх хүрээний сүрьеэтэй өвчтөний хавьтлын судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна.
- 5.5 Сүрьеэтэй өвчтөний эмчилгээг удирдамжийн дагуу явуулж, хяналтын шинжилгээнд хугацаанд нь хамруулж, үр дүнг тооцно.
- 5.6 Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөн шилжвэл сүрьеэгийн диспансерт мэдээлэх ба эмчилгээ тасалсан тохиолдолд шалтгааныг тодруулж холбогдох арга хэмжээ авна.
- 5.7 Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлоос 2 удаагийн сорьц авч цэрний шинжилгээнд хамруулж шаардлагатай тохиолдолд цээжний гэрлийн шинжилгээнд илгээнэ.
- 5.8 Жирэмсэн эмэгтэйчүүд болон гэр бүлийн гишүүдэд сүрьеэ өвчний талаар мэдээлэл өгч, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөнө.
- 5.9 Үйлчлэх хүрээний хүн амын дунд сүрьеэгээс сэргийлэх талаар ухуулга, мэдээлэл, сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулна.

Зургаа. Хорих 401, 429, 461, 407-р анги

- 6.1 Хорих ангийн сүрьеэгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бүрэн орон тоогоор тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээ авна.
- 6.2 Хорих ангиудад сүрьеэг илрүүлэх идэвхтэй үзлэгийг 401, 429, 461-р ангийн эмч нар тогтмол хийнэ.
- 6.3 Хорих 405, 407-р ангид эмчлэгдэх заалттай өвчтөний эмчилгээг ангийн эмч хийж, сүрьеэгийн мэргэжлийн эмч зөвлөгөө өгч, эмчилгээнд хяналт тавина.
- 6.4 Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг Хорих 429 дүгээр ангийн эмнэлэгт эмчлэнэ.
- 6.5 Сүрьеэтэй ялтанд өөр эмгэг хавсарсан тохиолдолд хавсарсан эмгэгийг хорих 401-р ангийн нэгдсэн эмнэлэгт эмчлэх арга хэмжээ авна.
- 6.6 Сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад цаг хугацаанд нь илгээх, сүрьеэтэй өвчтөн хугацаанаас өмнө суллагдсан тохиолдолд хорих 429 дүгээр ангийн статистикч эмч ХӨСҮТ-ийн СТСА-д мэдээлж, шилжиж очсон газрын харьяаллаар эмчилгээг үргэлжлүүлж, үр дүнг шилжүүлсэн газарт нь дүгнэнэ.

Долоо. Энэрэл эмнэлэг

- 7.1 Гэр оронгүй, тодорхой оршин суух хаяггүй сүрьеэтэй өвчтөнд сүрьеэгийн тусламж үйлчилгээг Энэрэл эмнэлэгт 6-8 сар шууд хяналттай хийж, эрсдэл өндөртэй үйлчүүлэгчдийн дунд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- 7.2 Сүрьеэгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагад цаг хугацаанд нь илгээнэ.

Эмэнд мэдрэг сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамж

Эмэнд мэдрэг сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, бүртгэн мэдээлэхэд энэхүү удирдамжийг мөрдөнө.

НЭГ. ЭМЭНД МЭДРЭГ СҮРЬЕЭ

- 1.1 **Тодорхойлолт:** Эмэнд мэдрэг сүрьеэгийн нянгаар үүсгэгдсэн халдварт өвчин
- 1.2 **Шалтгаан:** Сүрьеэгийн эмэнд мэдрэг *Mycobacterium tuberculosis complex*

ХОЁР. АНГИЛАЛ, ТОХИОЛДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Эмгэг өөрчлөлттэй эрхтэн тогтолцоогоор нь уушгины, уушгины бус эрхтэний сүрьеэ гэж ангилна.

2.1.1 **Уушгины сүрьеэ:** Уушгины эмнэл зүйн шинжүүд илэрч нян судлалын болон гэрлийн шинжилгээгээр батлагдсан тохиолдлыг тухайн ангилалд хамруулна.

Уушгины сүрьеэгийн зонхилон тохиолдох эмнэл зүйн хэлбэрүүд:

- Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
- Голомтот сүрьеэ
- Нэвчдэст сүрьеэ
- Уушгины туберкулем
- Уушгины тархмал сүрьеэ
- Уушгины хөндийт, сорвит хөндийт сүрьеэ

2.1.2 **Уушгины бус эрхтэний сүрьеэ:** Уушгинаас бусад эрхтэний эмнэл зүй илэрч эд, эсийн эсвэл нян судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдлыг тухайн ангилалд хамруулна.

Уушгины бус эрхтэний сүрьеэгийн зонхилон тохиолдох эмнэл зүйн хэлбэрүүд:

- Захын тунгалгийн булчирхайн сүрьеэ

-
- Тархи, нугасны сүрьеэ
 - Үнхэлцэг хальсны сүрьеэ
 - Уушгины гялтан хальсны сүрьеэ
 - Хэвлийн эрхтэний сүрьеэ
 - Шээс, бэлэг эрхтэний сүрьеэ
 - Яс, үений сүрьеэ

2.2 Эмнэл зүйн илрэлээр нь дунд, хүндэвтэр, хүнд гэж ангилна.

2.3 Нян судлалын шинжилгээг үндэслэж уушгины түрхэц эерэг, сөрөг гэж ангилна.

2.3.1 **Уушгины түрхэц эерэг сүрьеэ:** Цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян илэрсэн уушгины сүрьеэгийн тохиолдлыг тухайн ангилалд хамруулна.

2.3.2 **Уушгины түрхэц сөрөг сүрьеэ:** Эмнэл зүйд болон уушгины гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн өөрчлөлттэй эсвэл цэрний өсгөвөрлөх шинжилгээнд сүрьеэгийн нян ургасан, цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян илрээгүй тохиолдлыг тухайн ангилалд хамруулна

2.4 Тохиолдлын тодорхойлолт:

2.4.1 **Сүрьеэгийн сэжигтэй:** 14 хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгаж байгаа тохиолдол

2.4.2 **Шинэ:** Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаагүй, эсвэл сүрьеэгийн эмийг нэг сар хүртэлх хугацаагаар хэрэглэсэн тохиолдол

2.4.3 **Дахилт:** Сүрьеэгийн эмчилгээг амжилттай дуусгасан өвчтөн дахиж сүрьеэгээр өвчилж түрхэц эерэг болсон тохиолдол

2.4.4 **Шилжиж ирсэн:** Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байх хугацаанд өөр аймаг, дүүргээс шилжиж ирсэн тохиолдол

2.4.5 **Эмчилгээ тасалсны дараах:** Сүрьеэгийн эмчилгээг 2 сар ба түүнээс дээш хугацаагаар орхисны дараа түрхэц эерэг болж эмчилгээ дахин эхэлж байгаа тохиолдол

2.4.6 **Үр дүнгүй:** Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 дахь сард түрхэц эерэг байгаа тохиолдол

2.4.7 **Бусад:** Дээр дурьдагдсан ангилалд хамруулах боломжгүй тохиолдол

2.5 Эмчилгээний үр дүн

- 2.5.1 **Эдгэрсэн:** Уушгины сүрьеэтэй түрхэц эерэг өвчтөн эмчилгээний хяналтын сүүлийн 2 ба түүнээс дээш удаагийн түрхэцийн шинжилгээнд дараалан «сөрөг» болсон тохиолдол
- 2.5.2 **Эмчилгээ дуусгасан:** Уушгины сүрьеэтэй түрхэц эерэг өвчтөн эмчилгээний хяналтын шинжилгээг бүрэн хийлгээгүй, эсвэл уушгины сүрьеэтэй түрхэц сөрөг болон уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэсэн тохиолдол
- 2.5.3 **Үр дүнгүй:** Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 дахь сар болон түүнээс хойш хугацаанд түрхэц эерэг тохиолдол
- 2.5.4 **Тасалсан:** Сүрьеэгийн эмчилгээний хугацаанд дараалан 2 сар, түүнээс дээш хугацаагаар эмчилгээ тасалсан тохиолдол
- 2.5.5 **Шилжсэн:** Сүрьеэгийн эмчилгээний хугацаанд өөр аймаг, дүүрэгт шилжсэн тохиолдол
- 2.5.6 **Нас барсан:** Сүрьеэгийн эмчилгээний хугацаанд ямар нэг шалтгаанаар нас барсан тохиолдол
- 2.5.7 **Эмчилгээний амжилт:** Эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан уушгины түрхэц эерэг тохиолдол

2.6 Хүндрэл:

- 2.6.1 Хүндрэлгүй
- 2.6.2 Хүндрэлтэй: цус алдах, уушгинд хий хурах, уушги тэлэгдэх, амин эрхтэнүүдийн дутмагшил, хавсарсан өвчнүүдийн хүндрэл г.м

ГУРАВ. ОНОШЛОГОО

Эмэнд мэдрэг сүрьеэгийн оношлогоонд эмнэл зүйн болон багажийн аргуудыг хэрэглэнэ.

3.1 Эмнэл зүйн оношлогоо

3.1.1 Асуумжаар илрэх шинж тэмдэг, сүрьеэгийн хавьтал, сүрьеэгээр өвчлөхөд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг тодруулна.

Хүүхдэд: ойрын хавьтал, дархлаажуулалт, өсөлт хөгжилтийн байдал, суурь өвчин

3.1.2 Бодит үзлэгээр өвчтөний биеийн байдлыг үнэлж тухайн эрхтэнд үүссэн өөрчлөлтийг илрүүлнэ.

Хүүхдэд: туберкулины хэт мэдрэгшлийн шинжүүд (нүдний салстын үрэвсэл, улаан булдруу), өсөлт хөгжилтийн байдал, БЦЖ вакцины сорвижилт, нэмэлт үзлэгүүд

Үндсэн шинжилгээ:

- Уушгины сүрьеэ: цэрний түрхэц, өсгөвөрлөх, цээжний гэрлийн шинжилгээ
- Уушгины бус эрхтэний сүрьеэ: эд, эс, нян судлалын шинжилгээ, гэрлийн шинжилгээ, иммунологи, молекул биологийн шинжилгээ

Хүүхдэд: туберкулины сорил, ходоодны угаадсанд нян судлалын шинжилгээ

Туслах шинжилгээ: цус, шээсний ерөнхий шинжилгээ, биохими, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ

3.2 Оношлогооны аргууд

3.2.1 Цэр цуглуулах, хадгалах, тээвэрлэх.

Өвчтөнөөс аргачлалын дагуу хоёр удаагийн цэр авна. Нэг нь тухайн үеийн, нөгөө нь дараа өдрийн өглөөний өлөн үед авсан цэр байна. Цэрийг эргэдэг тагтай, том амсартай, нэг удаагийн саванд авч хөргөгчинд (+2 - +8оС) хадгална. Био аюултай материал тээвэрлэх журмын дагуу богино хугацаанд лабораторид хүргэнэ.

3.2.2 Түрхэцийн шинжилгээ

Уушгины сүрьеэ, уушгины бус эрхтэний сүрьеэг оношлоход түрхэцийн шинжилгээг хэрэглэнэ. Сорьцоос наалдац бэлдэж Циль-Нильсены аргаар будаж 1000 дахин өсгөх чадвартай бичил харуураар шинжилнэ. Хүчилд тэсвэртэй нян илэрвэл түрхэц эерэг, илрээгүй тохиолдолд сөрөг гэж тооцно.

3.2.3 Өсгөвөрлөх шинжилгээ

Эмчлэгч эмчийн заалтаар онош тодруулах, эмэнд дасалтай эсэхийг тогтоох зорилгоор сорьцыг өсгөвөрлөх шинжилгээнд хамруулна.

Сорьцонд зааврын дагуу жигдлэн боловсруулалт хийж 2%-ийн Огава, Левенштэйн-Иенсеней тэжээлт орчинд тарьж +37оС-ийн хэмд 8 долоо хоног хүртэл ургуулан

нянгийн ургалтыг долоо хоног тутам шалган хариуг мэдээлнэ.

3.2.4 Гэрлийн шинжилгээ

Эгц, хажуу, зүслэгтэй зураг авч эмгэг өөрчлөлтийн байрлал, тархалт, явц, идэвхжлийг тодорхойлно.

3.2.5 Туберкулины сорил

Сүрьеэгийн халдвар авсан эсэхийг тодорхойлох зорилгоор туберкулины сорилыг 0-16 насны хүүхдэд тавьж 48-72 цагийн дараа хариуг дараах тохиолдолд эерэг гэж үнэлнэ:

- БЦЖ вакцинаар дархлаажуулагдсан эсэхээс үл хамааран 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү
- ХДХВ-ийн халдвартай, эсвэл хүнд тураалтай буюу хоол тэжээлийн дутагдалтай хүүхдэд 5 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү

Туберкулины сорилын хариу урвал хуурамч эерэг, сөрөг гарах тохиолдол

- Хуурамч эерэг: сорилын хариу буруу унших, сүрьеэгийн бус микобактерийн халдвар
- Хуурамч сөрөг: ХДХВ халдвартай, туберкулины хадгалалтын горим алдагдсан, вирүс, нянгийн гаралтай халдвар, вирүсийн вакцин хийлгэснээс хойш 6 сарын дотор, хоол тэжээлийн дутал, тураал, дархлал дарангуйлах эмчилгээ, уургийн дутал, архаг болон хурц тархмал сүрьеэтэй тохиолдол

3.2.6 Эд, эсийн шинжилгээ

Үрэвсэлт өөрчлөлттэй эрхтэнээс авсан сорьцонд эд, эсийн шинжилгээ хийж өвөрмөц үрэвслийн шинжийг илрүүлнэ.

3.2.7 Иммунологийн шинжилгээ

Сүрьеэгийн нянгийн гадаргуугийн эсрэгтөрөгчийн эсрэг үүссэн эсрэгбие илрүүлэх хурдавчилсан арга бөгөөд цусны ийлдсэнд үзэж эерэг, сөрөг гэж үнэлнэ.

ДӨРӨВ. ЭМЧИЛГЭЭ

Сүрьеэтэй өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд шууд хяналттай богино хугацааны эмчилгээний зарчмыг мөрдөж ажиллана.

4.1 Хоол эмчилгээ

Өвчтөний эмчилгээний хоолны илчлэгийг эмчилгээ, сувиллын хоолны удирдамжийн дагуу хоол №11-ийг өдөрт 5-6 удаагийн давтамжтай хэрэглэнэ*. Энэ нь үрэвслийн эсрэг биеийн эсэргүүцлийг сайжруулах зориулалттай, уураг ба илчлэгийг 20 хувиар нэмэгдүүлсэн, өөх тос, нүүрс усыг физиологийн хэрэгцээнд тооцож зохицуулсан, амин дэм, эрдэсээр баялаг агууламжтай хоол юм.

Уг хоолны хоногт ноогдох найрлагад уураг 120-130 гр (60% нь А), Өөх тос 75-80 гр (60% нь У), Нүүрс ус 400-450 гр, Илчлэг 3000-3200 ккал, давс 10 гр тус тус ноогдоно. Сүрьеэтэй өвчтөнд хориглох хоол, хүнс байхгүй бөгөөд бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхээс гадна сүү, сүүн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх хэрэгтэй.

4.2 Сүрьеэгийн эсрэг эмийн тун

Эмийн нэр	Зөвлөмж болгож буй тун		Эмийн үйлчилгээ
	Тун (мг/кг)	Хоногийн дээд тун (мг)	
Изониазид (H)	5 (4-6)	300	Нян устгах
Рифампицин (R)	10 (8-12)	600	Нян устгах
Пиразинамид (Z)	25 (20-30)	1600	Нян устгах
Этамбутол (E)	Хүүхдэд 20 (15-25) Том хүнд 15 (15-20)	1200	Нянгийн үржлийг дарангуйлах
Стрептомицин (S)	15 (12-18)	1000	нян устгах

4.3 Сүрьеэгийн эмчилгээний бүлэг ба горим

Сүрьеэгийн эмчилгээ эрчимт болон үргэлжлэх шатаас бүрдэнэ.

4.3.1 I Бүлэг

- Шинэ түрхэц эерэг уушгины сүрьеэ
- Шинэ түрхэц сөрөг уушгины талбайг их хэмжээгээр хамарсан өөрчлөлттэй
- Шинэ уушгины бус эрхтэний сүрьеэгийн хүнд хэлбэр

Эмчилгээний горим: 2HRZE (S) / 4HR

4.3.2 II Бүлэг

- Дахилт
- Үр дүнгүй эмчлэгдсэн
- Эмчилгээ тасалсны дараах

Эмчилгээний горим: 2HRZES / 1HRZE / 5HRE

4.3.3 III Бүлэг

- Шинэ, түрхэц сөрөг уушгины сүрьеэ
- Шинэ, уушгины бус эрхтэний (I бүлэгт орсноос бусад) сүрьеэ

Эмчилгээний горим: 2HRZE / 4HR

4.3.4 Эмийн тогтсон тунтай хослол

Эмийн бэлдмэлийн нэр (эмийн товчлол, эмийн хэлбэр)	Биеийн жинд тохирсон эмийн тун		
	30-39 кг	40-54 кг	55-70 кг
I, III бүлэг			
2RHZE (150/75/400/275) / 4RH (150/75)	2 шахмал	3 шахмал	4 шахмал
II бүлэг			
3RHZE (150/75/400/275) / 5RHE (150/75/275)	2 шахмал	3 шахмал	4 шахмал
2S (1 г флакон)	1 мл 500 мг	2 мл 750 мг	3 мл 1000 мг

4.4 Хүүхдийн сүрьеэгийн эмчилгээ

Хүүхдийн жинд тохирох доорхи тунг 3 сараас дээш настай хүүхдэд хэрэглэхийг ДЭМБ-аас зөвлөмж болгож байгаа ба хоногийн хамгийн дээд тун насанд хүрэгчдийн хоногийн хамгийн дээд тунгаас хэтрэхгүй байна.

4.4.1 Хүүхдийн сүрьеэгийн эсрэг эмийн тун

Эмийн нэр	Зөвлөмж болгож буй тун
	Тун (мг/кг/хоног)
Изониазид (H)	10 (10-15)
Рифампицин (R)	15 (10-20)
Пиразинамид (Z)	35 (30-40 мг)
Этамбутол (E)	20 (15-25)
Стрептомицин (S)	15 (12-18)

Хүүхдийн сүрьеэгийн эмчилгээнд тогтсон тунтай эмийн хослолыг хэрэглэх заавар:

Рифампицин 250 мг, изониазид 150 мг, пиразинамид 400 мг, этамбутол 250 мг тогтсон тунтай эмийн хослолыг 5-30 кг жинтэй хүүхдийн сүрьеэгийн эрчимт шатны эмчилгээний горимд хэрэглэхэд тохиромжтой.

Бусад тогтсон тунтай эмийн хослол болох рифампицин 250 мг + изониазид 150 мг + пиразинамид 400 мг 3 эмийн хослолыг этамбутолгүй горим сонгосон тохиолдолд эрчимт шатны эмчилгээнд, рифампицин 250 мг + изониазид 150 мг 2 эмийн хослолыг үргэлжлэх шатанд хэрэглэнэ.

4.4.2 Хүүхдийн сүрьеэгийн шинэ тохиолдлын эмчилгээний горим 5-20 кг жинтэй хүүхдийн эмчилгээ:

Эмийн нэр (эмийн товчлол, тун)	Биеийн жинд тохирсон эмийн тун		
	5-7 кг	8-14 кг	15-20 кг
Этамбутолгүй			
2RHZ* (60/30/150)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
2RH* (60, 60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал
4RH* (60/30)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
4RH* (60/60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал
Этамбутолтой			
2RHZ* (60/30/150)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
2RH* (60, 60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал
2E (100)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
4RH* (60/30)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
4RH* (60/60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал

20-30 кг жинтэй хүүхдийн эмчилгээний горим:

Эмийн нэр (эмийн товчлол, тун)	Биеийн жинд тохирсон эмийн тун (20-30 кг)
Этамбутолгүй	
2RHZ (150/75/400)	2 шахмал
2RH* (60, 60)	2 шахмал
2Z(400)	2 шахмал
4RH (150/75)	2 шахмал
4RH* (60, 60)	2 шахмал
Этамбутолтой	
2RHZE (150/75/400/275)	2 шахмал
2RH* (60, 60)	2 шахмал
4RH (150/75)	2 шахмал
4RH* (60/60)	2 шахмал

Хүүхдийн сүрьеэгийн давтан эмчилгээний горим:

Эмийн нэр (эмийн товчлол, тун)	Биеийн жинд тохирсон эмийн тун		
	5-7 кг	8-14 кг	15-20 кг
3RHZ* (60/30/150)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
3RH* (60, 60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал
3E (100)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
5RH* (60/30)	1 шахмал	2 шахмал	3 шахмал
5RH* (60, 60)	1 шахмал	1 шахмал	2 шахмал
5E (100)	1 шахмал	2 шахмал	3 шахмал

20-30 кг жинтэй хүүхдэд:

Эмийн нэр (эмийн товчлол, тун)	Биеийн жинд тохирсон эмийн тун (20-30 кг)
3RHZE (150/75/400/275)	2 шахмал
3RH* (60, 60)	2 шахмал
5RH (150/75)	2 шахмал
5RH* (60, 60)	2 шахмал
5E (400)	1 шахмал

* гэсэн тэмдэгтэй эмийг түлхүү хэрэглэхийг зөвлөмж болгоно.

Хүүхдийн сүрьеэгийн эмчилгээний явцад анхаарах зүйлс:

- Эмчилгээний явцад сар бүр хүүхдийн биеийн жинг хянах
- Хүүхдийн биеийн жин өөрчлөгдсөн тохиолдолд эмийн тунг тохируулан өөрчлөх
- Тогтсон тунтай хослолын эмийн тунг сайтар шалгаж эмийн тун хэтрэн, эмийн хордлого үүсэхээс зайлсхийх
- 30–аас дээш кг жинтэй хүүхдийг насанд хүрэгчдийн эмчилгээний горимын дагуу эмчлэх

4.5 Сүрьеэгийн өвөрмөц эмчилгээний горим

4.5.1 Сүрьеэгийн менингит ба тархмал сүрьеэтэй хүүхдийн эмчилгээ

Сүрьеэгийн менингит ба тархмал хэлбэрийн сүрьеэтэй хүүхдийг эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ. Эмчилгээний горим: 2HRZE (S) / 4HR; 2HRZE (S) / 6HE

4.5.2 Тархмал, хүнд хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээ

Сүрьеэгийн менингит, хурц тархмал сүрьеэ, мэдрэл гэмтсэн нурууны сүрьеэ, уушгины сүрьеэгийн зарим хүнд хэлбэрийн үед эмнэл зүйн байдлаас хамаарч үргэлжлэх

-
- шатанд изониазид ба рифампициныг 7 сар хэрэглэж болно.
- 4.5.3 Мэс заслын эмчилгээ
Эмийн эмчилгээгээр бүрэн эмчлэгдэх боломжгүй, уушгины сүрьеэгийн хүндрэл, үнхэлцэг хальс, яс үе, хэвлийн сүрьеэ, буглаа, идээт үрэвслийн үед мэс засал эмчилгээг эмийн эмчилгээтэй хавсарч хийнэ.
- 4.5.4 Сүрьеэтэй жирэмсэн өвчтөний эмчилгээний онцлог
Сүрьеэтэй жирэмсэн болон хөхүүл эхэд сүрьеэгийн эмчилгээ эхэлсэн тохиолдолд бүрэн хийнэ. Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа үед хүүхдээ хөхүүлж болно. Эмчилгээнд стрептомицинийг хэрэглэхийг хориглоно. Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа жирэмсэн, хөхүүл эмэгтэйд пиридоксиныг нэмэлтээр өгнө.
- 4.5.5 Жирэмслэхээс хамгаалах дааврын бэлдмэл хэрэглэж буй үеийн эмчилгээ
Рифампицин нь дааврын бэлдмэлийн үйлчилгээг бууруулдаг учраас эстрогений тун 50 мг/кг-аас дээш бэлдмэлийг эсвэл өөр хэлбэрийн хамгаалах хэрэгсэл зөвлөмж болгоно.
- 4.5.6 Элэгний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөний эмчилгээ
Элэгний хүнд хэлбэрийн эмгэг, элэгний эмгэгийн сэдрэл даамжирсан үед пиразинамидыг хэрэглэхгүй, элэгний үйл ажиллагааг тогтмол хянаж 2SHE/10HE горимоор эмчилнэ.
Элэгний хурц үрэвсэлтэй үед идэвхжлийг намжтал сүрьеэгийн эмчилгээг хойшлуулна.
- 4.5.7. Бөөрний дутагдалтай өвчтөний эмчилгээ
Бөөрний хүнд дутагдалтай өвчтөнд захын мэдрэлийн гэмтэл үүсэхээс сэргийлж изониазидтай хамт пиридоксин хэрэглэнэ. Этамбутол, стрептомициныг эмчийн хяналтанд хэрэглэнэ. Хэрэглэх горим: 2HRZ/6HR
- 4.5.9 Чихрийн шижинтэй өвчтөний эмчилгээ
Пиразинамидыг хэрэглэхдээ цусан дахь сахарын хэмжээг хоногт 1-2 удаа хянана.
- 4.5.10 Бусад эмчилгээ
Шаардлагатай тохиолдолд хордлого тайлах, зүрх судасны үйл ажиллагааг дэмжих, амин дэм, гаж нөлөө, хүндрэлийн эсрэг шинж тэмдгийн эмчилгээ хийнэ.

ТАВ. ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч оношлогдож бүртгэгдсэн өвчтөний биеийн байдал, эмнэл зүйн илрэл, нийгмийн байдал, халдвар хамгааллын эрсдэл зэргийг харгалзан ямар шатлалд (тасаг, сум, өрхийн эмнэлэг, өдрийн эмчилгээний цэг, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн)-д шууд хяналттай эмчлэхийг шийдвэрлэнэ.

Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг доорх үндсэн чиглэлийн дагуу хийнэ. Үүнд:

- Сүрьеэгийн эмийг шууд хяналттай уулгах
- Сүрьеэгийн эмийн гаж нөлөөг хянах
- Эмчилгээний үр дүнгийн хяналтыг уушгины сүрьеэтэй шинэ тохиолдолд 2 (3), 5, 6 дахь сард; давтан тохиолдолд 3, 5, 8 дахь сард цэрний 2 сорьцоор түрхэцийн шинжилгээгээр хийнэ. Эмчилгээний төгсгөлд цээжний гэрлийн шинжилгээ хийнэ.

5.1 Өрх, сумын эмнэлэг

5.1.1 Уушгины түрхэц сөрөг сүрьеэтэй, биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилтэй тохиолдол,

5.1.2 Уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилтэй тохиолдол,

5.1.3 Уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй, эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилтэй хүүхдийн сүрьеэгийн тохиолдлын эрчимт болон үргэлжлэх шатны эмчилгээ, хяналтыг хийнэ.

5.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер

5.2.1 Уушгины түрхэц эерэг болон сөрөг сүрьеэтэй, биеийн байдал дунд, хүндэвтэр, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилийн өмнөх үед байгаа тохиолдол,

5.2.2 Уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал дунд, хүндэвтэр, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилийн өмнөх үед байгаа тохиолдол,

-
- 5.2.3 Уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал дунд, хүндэвтэр, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилийн өмнөх үед байгаа хүүхдийн сүрьеэгийн тохиолдол,
 - 5.2.4 Уушгины түрхэц эерэг болон сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэтэй биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилийн үед байгаа жирэмсэн болон төрсний дараах тохиолдлын эрчимт шатны эмчилгээ, хяналтыг хийнэ.
 - 5.2.5 Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмчдээр дурдсан тохиолдлын үргэлжлэх шатны эмчилгээг сайн дурын идэвхтэн, өрх, сумын эмнэлэг, диспансерийн хяналтанд үргэлжлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.3 Сүрьеэгийн клиникийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, Энэрэл эмнэлгийн сүрьеэгийн тасаг

- 5.3.1 Уушгины түрхэц эерэг болон сөрөг сүрьеэтэй, биеийн байдал хүндэвтэр, хүнд, хавсарсан эмгэгтэй, эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшил алдагдсан тохиолдол
- 5.3.2 Уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал хүндэвтэр, хүнд, хавсарсан эмгэгтэй, эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшил алдагдсан тохиолдол,
- 5.3.3 Уушгины сүрьеэ бусад эрхтэний сүрьеэтэй хавсарсан, биеийн байдал хүндэвтэр, хүнд тохиолдол,
- 5.3.4 Уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал хүндэвтэр, хүнд, хавсарсан эмгэгтэй, эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшил алдагдсан хүүхдийн сүрьеэгийн тохиолдол,
- 5.3.5 Уушгины түрхэц эерэг болон сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэтэй биеийн байдал хүндэвтэр, хүнд, хавсарсан эмгэгийн ээнэгшил алдагдсан жирэмсэн болон төрсний дараах тохиолдол,
- 5.3.6 Эмийн гаж нөлөө хүчтэй илэрсэн, эмэнд дасалтай сүрьеэгийн хавьтал, өмнөх эмчилгээ тасалсан, үр дүнгүй эмчлэгдсэн, ДОТС-ын төвөөс алслагдсан, өдөр бүр эмээ хяналттай уух боломжгүй, тодорхой оршин суух хаяггүй, ядуу, орон гэргүй, асран хамгаалах хүнгүй, архи, мансууруулах бодист донтогсод зэрэг тохиолдлын

эрчимт шатны эмчилгээ хяналтыг 14 буюу түүнээс дээш хоног хийнэ.

5.3.7 Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч дээр дурдсан тохиолдлын үргэлжлэх шатны эмчилгээг сайн дурын идэвхтэн, өрх, сумын эмнэлэг, диспансерийн хяналтанд үргэлжлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.4 Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, хоолтой эмчилгээний цэг

5.4.1 Уушгины түрхэц эерэг болон сөрөг сүрьеэтэй, биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилтэй тохиолдол,

5.4.2 Уушгины бус эрхтэний сүрьеэтэй, биеийн байдал дунд, хавсарсан эмгэггүй эсвэл хавсарсан эмгэгийн ээнэгшилтэй тохиолдлын эрчимт болон үргэлжлэх шатны эмчилгээ, хяналтыг хийнэ.

5.5 Хүнд өвчтөнг эмнэлэг хооронд шилжүүлэх

5.5.1 Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт эмчлэгдэж байгаа сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг сүрьеэгийн онош тодруулах шинжилгээг бүрэн хийсний дараа сүрьеэгийн мэргэжлийн эмчийг дуудаж зөвлөгөө авна. Тухайн тохиолдолд нян судлал, эд эсийн шинжилгээний аль нэгээр онош батлагдсан тохиолдолд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.5.2 Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт эмчлэгдэж байхдаа оношлогдсон сүрьеэтэй өвчтөний биеийн байдал хүнд, тээвэрлэх боломжгүй үед халдвар ялгаруулж байгаа эсэхээс үл хамааран биеийн байдал тогтворжтол тухайн эмнэлэгт сүрьеэгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

5.5.3 Хавсарсан эмгэгийн улмаас биеийн байдал хүнд, тээвэрлэх боломжгүй сүрьеэ оношлогдсон өвчтөнийг хүнд байдлаас гартал тухайн эмнэлэгт сүрьеэгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

ЗУРГАА. БҮРТГЭН МЭДЭЭЛЭХ

Сүрьеэ өвчнийг олон улсын өвчний аравдугаар ангиллын дагуу А15-А19 (Tuberculosis) кодоор бүртгэнэ.

- 6.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч эмэнд мэдрэг сүрьеэгийн тохиолдлыг «Сүрьеэтэй өвчтөний бүртгэл» (ТВ-03)-д бүртгэн «Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт» (ТВ-01)-ыг хөтлөнө.
- 6.2 «Шинэ илэрсэн болон давтан бүртгэгдсэн өвчтөний сарын тайлан» (ТВ-07), «Уушгины түрхэц эерэг өвчтөний эмчилгээний 2, 3 дахь сард түрхэц сөрөгт шилжсэн байдал» (ТВ-14), «12-15 сарын өмнө бүртгэгдсэн сүрьеэтэй өвчтөний эмчилгээний үр дүнгийн тайлан» (ТВ-08), Сүрьеэгийн лабораторийн түрхэцийн шинжилгээний тайланг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон дараах сар, улирлын эхний 7 хоногт багтааж сүрьеэгийн зохицуулагч эмч, статистикч эмчээр хянуулан Сүрьеэгийн тандалт судалгааны албанд илгээнэ.
- 6.3 Эмчлэгч эмч «Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчдийн карт» (ТВ-13)-ыг хөтлөж, өвчтөн эмнэлгээс гарах үед эмчилгээг үргэлжлүүлэх байгууллагад шилжүүлнэ.
- 6.4 Сүрьеэгийн зохицуулагч эмч «Сүрьеэгийн байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан» (ТВ-10)-г гарган дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сүрьеэгийн тандалт судалгааны албанд ирүүлнэ.
- 6.5 «Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт»(ТВ-01)-ыг эмчилгээ дууссанаас хойш сарын дотор Сүрьеэгийн тандалт судалгааны албанд илгээнэ.
- 6.6 Өвчтөн эмчилгээний хугацаанд шилжсэн тохиолдолд «Өвчтөнг шилжүүлсэн мэдээ»(ТВ-09)-г 3 хувь бичиж өвчтөн, эмчилгээг үргэлжлүүлэх эрүүл мэндийн байгууллага, Сүрьеэгийн тандалт судалгааны албанд тус тус өгнө. Хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага эргэн мэдээлж эмчилгээний үр дүнг анх бүртгэсэн газарт тооцно.
- 6.7 Сүрьеэгийн I эгнээний эмийн тайланг сар бүрийн 25-ны өдөр, II эгнээний эм, гаж нөлөөний эм, урвалж бодисын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон, ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт, судалгааны албанд ирүүлнэ.

Эмэнд дасалтай сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамж

Сүрьеэ өвчний онош хожимдох, эмчилгээ хяналтгүй хийх, сүрьеэгийн эмийг зүй бусаар хэрэглэх, эмчилгээ дутуу буруу хийх, эмийн хангамж тасалдах, чанаргүй эм хэрэглэх зэрэг шалтгааны улмаас эмэнд дасалтай сүрьеэ үүсч улмаар сүүлийн жилүүдэд эмэнд дасалтай сүрьеэ дэлхийн хэмжээнд ихсэх хандлагатай байна.

Зарим тохиолдолд сүрьеэгийн эм хэрэглээгүй боловч эмэнд дасалтай нянгаар халдварласан тохиолдолд эмэнд дасалтай сүрьеэгээр өвчилж болно.

Эмэнд дасалтай сүрьеэ үүсэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, оношлох, бүртгэх, мэдээлэх, эмчлэх, хянах ажлыг зохион байгуулахад энэхүү удирдамжийг мөрдөнө.

Нэг. Тодорхойлолт, ангилал

Сүрьеэгийн эсрэг эмэнд тэсвэртэй нянгаар үүсгэгдсэн нь лабораториор батлагдсан тохиолдлыг эмэнд дасалтай сүрьеэ (ЭДС) гэнэ.

1.1 Эмэнд даслыг дараах байдлаар ангилна.

- Нэг эмэнд дасалтай
- Бусад эмэнд дасалтай
- Олон эмэнд дасалтай
- Маш олон эмэнд дасалтай сүрьеэ

1.1.1 **Нэг эмэнд дасалтай сүрьеэ:** сүрьеэгийн эсрэг аль нэгэн эмэнд дасалтай;

1.1.2 **Бусад эмэнд дасалтай сүрьеэ (БЭДС):** изониазид, рифампицины хослолоос бусад нэгээс дээш тооны эмэнд дасалтай

1.1.3 **Олон эмэнд дасалтай сүрьеэ (ОЭДС):** изониазид, рифампацинд хоёуланд нь дасалтай

1.1.4 **Маш олон эмэнд дасалтай (МОЭДС):** олон эмэнд дасалтайн дээр фторхинолоны бүлгийн аль нэг эм болон 2-р эгнээний тарьж хэрэглэдэг эмүүдийн аль нэгэнд дасалтай

1.2 Эмэнд даслыг үүсэх шалтгаанаар:

- Анхдагч дасал
 - Хоёрдогч дасал
- 1.2.1 Анхдагч дасал: сүрьеэгийн эмчилгээ огт хийлгэж байгаагүй буюу нэг сараас доош хугацаагаар хийлгэсэн өвчтөнд илрэх хэлбэр
- 1.2.2 Хоёрдогч дасал: сүрьеэгийн эсрэг эмчилгээний явцад үүссэн хэлбэр

1.3 Тохиолдлын тодорхойлолт

- 1.3.1 **Шинэ:** сүрьеэгийн эмчилгээ огт хийлгэж байгаагүй эсвэл 1 сар хүртлэх хугацаанд сүрьеэгийн эм хэрэглэж байсан тохиолдол
- 1.3.2 **Дахилт:** Урьд нь хийлгэсэн сүрьеэгийн эмчилгээний үр дүн эдгэрсэн эсвэл эмчилгээ дуусгасан боловч тодорхой хугацааны дараа түрхэц болон өсгөвөрлөх шинжилгээгээр дахин эерэг гарсан тохиолдол
- 1.3.3 **Эмчилгээ тасалсны дараах:** 2 сар түүнээс дээш хугацаагаар сүрьеэгийн эсрэг эмчилгээг тасалсаны дараа түрхэц болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг гарч эмчилгээнд давтан орж байгаа тохиолдол
- 1.3.4 **I бүлгийн эмчилгээ үр дүнгүй:** I бүлгийн эмчилгээний 5 дахь сард түрхэц эерэг тохиолдол
- 1.3.5 **II бүлгийн эмчилгээ үр дүнгүй:** II бүлгийн эмчилгээний 5 дахь сар, түүнээс дээш түрхэц эерэг тохиолдол
- 1.3.6 **Шилжиж ирсэн:** Эмчилгээний хугацаанд өөр аймаг, дүүргээс ирсэн тохиолдол
- 1.3.7 **Бусад:** Өмнөх эмчилгээний үр дүн тодорхойгүй түрхэц эерэг, горимын бус эмчилгээ хийлгэж байсан, урьд нь хэд хэдэн удаагийн эмчилгээ үр дүнгүй болсон, өмнө нь уушгины бус эрхтэний сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байсан зэрэг тохиолдол

1.4 Эмчилгээний үр дүнгийн тодорхойлолт

- 1.4.1. Халдваргүй болсон: Өсгөвөрлөх шинжилгээ дараалан 2 удаа сөрөг гарсан тохиолдлыг;
- 1.4.2 Эдгэрсэн: Эмчилгээний сүүлийн 12 сарын хугацаанд 30 хоногийн зайтай хийсэн төгсгөлийн:

-
- 5 удаагийн өсгөвөрлөх шинжилгээ дараалан сөрөг гарсан тохиолдол
 - 3-4 өсгөвөр дараалан сөрөг, эмнэл зүйн хувьд сайжирсан тохиолдол
- 1.4.3 **Эмчилгээ дуусгасан:** Эмчилгээ бүрэн хийлгэсэн эмчилгээний төгсгөлд өсгөвөр сөрөг доорх тохиолдлыг:
- Эмчилгээний хяналтын шинжилгээ бүрэн хийгдээгүй
 - 3-4 өсгөвөр дараалан сөрөг, эмнэл зүйн хувьд сайжралгүй
 - Уушгины түрхэц сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэ
- 1.4.4 **Нас барсан:** Эмчилгээний хугацаанд ямар нэг шалтгаанаар нас барсан тохиолдол
- 1.4.5 **Эмчилгээ тасалсан:** Эмчилгээний хугацаанд 2 сар түүнээс дээш хугацаанд эмчилгээ тасалсан тохиолдлыг;
- 1.4.6 **Үр дүнгүй:** Сүүлийн 3 удаагийн өсгөвөрлөх шинжилгээний 1-ээс дээш тохиолдол өсгөвөр эерэг гарсан тохиолдлыг;
- 1.4.7 **Шилжсэн:** Эмчилгээний хугацаанд өөр аймаг, дүүрэгт шилжсэн тохиолдол

Хоёр. Илрүүлэлт

2.1 Эмэнд дасалтай сүрьеэгийн сэжигтэй дараах тохиолдолд эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ хийнэ:

- 2.1.1 Сүрьеэгийн I ба II бүлгийн шууд хяналттай эмчилгээний 3 дахь сард түрхэц эерэг тохиолдол
- 2.1.2 Сүрьеэгийн I ба II бүлгийн шууд хяналттай эмчилгээний 5 дахь сард түрхэц эерэг тохиолдол
- 2.1.3 Сүрьеэгийн I ба II бүлгийн эмчилгээ тасалсны дараах түрхэц эерэг тохиолдол Сүрьеэгийн I ба II бүлгийн эмчилгээний дахилттай тохиолдол
- 2.1.4 Бусад: 1 сараас дээш хугацаанд эмчилгээ хийлгэсэн дараах тохиолдлууд
- Өмнөх эмчилгээний бүлэг, горим тодорхойгүй эсвэл түрхэц сөрөг оношлогдсон
 - Эмчилгээний эхэнд сөрөг байсан өвчтөн эмчилгээний явцад эерэг болсон
 - Эмчилгээг 2 сараас дээш хугацаанд тасалсны дараа түрхэц сөрөг байгаа

-
- 2.1.5 Сүрьеэгийн түрхэц эерэг архаг тохиолдол
 - 2.1.6 ЭДС-тэй өвчтөний гэр бүлийн гишүүд, ойрын хавьтлаас илэрсэн сүрьеэгийн тохиолдол
 - 2.1.7 ХДХВ-ийн халдвартай сүрьеэтэй тохиолдол

Гурав. Оношлогоо

ЭДС-ийн оношийг дараах байдлаар баталгаажуулна.

- 3.1 **Ялган дүйлт:** Өсгөвөрлөх шинжилгээнд ургасан *M.tuberculosis complex*-ийн ялган дүйлтийг ургалтын байдал, ниацин, паранитробензоны хүчил, каталазын сорилууд ашиглана.
- 3.2 **Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ:** Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээг дасал тодорхойлох шаардлагатай өсгөвөр эерэг гарсан тохиолдолд сүрьеэгийн эсрэг нэгдүгээр эгнээний изониазид, рифампицин, этамбутол, стрептомицин, хоердугаар эгнээний канамицин, офлаксацин, циклосерин, этионамид эсвэл протионамид, ПАСК зэрэг эмүүдэд эмчийн заалтаар тодорхойлно.

Эмийн шингэрүүлэлтийн арга ашиглан Левенштэйн-Иенсений тэжээлт орчинд 28-42 хоногийн дотор эмэнд даслыг тодорхойлно.

Эмийн шалгуур концентраци 1%-аас их тохиолдолд тухайн эмэнд тэсвэртэй гэж тооцно.

Эмэнд мэдрэг чанарыг тодорхойлоход шингэн тэжээлт орчин, молекул биологийн аргыг ашиглаж болно.

Дөрөв. Бүртгэн мэдээлэх

4.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч:

- 4.1.1 ЭДС-ийн сэжигтэй тохиолдлыг олон эмэнд дасалтай сүрьеэ байж болзошгүй өвчтөний бүртгэл (ОЭДС-15)-д бүртгэн сорьц цуглуулж эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээнд явуулах маягт (ОЭДС-06)-ыг бөглөн ХӨСҮТ-ийн СТСА-ны лавлах лабораторид илгээнэ
- 4.1.2 Онош батлагдсан тохиолдолд эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцүүлж ЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөний шийдвэр (ОЭДС-16)-ийг үндэслэн эмчилгээнд оруулна.

- 4.1.3 Эмчлэгдэх шийдвэр гарсан тохиолдлыг ОЭДС-тэй өвчтөнийг бүртгэх маягт (ОЭДС-03)-д бүртгэнэ.
- 4.1.4 ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт (ОЭДС-01)-ыг нээж, эрчимт шатны эмчилгээ хийх нэгж байгууллагад хүлээлгэн өгнө.
- 4.1.5 Хэрэв эмчилгээний явцад шилжих тохиолдолд өвчтөнг шилжүүлэх маягт (ОЭДС-09)-ыг 3 хувь бичиж өвчтөн, эмчилгээг үргэлжлүүлэх эрүүл мэндийн байгууллага, ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд илгээнэ.
- 4.1.6 Тайлангийн сарын 25-аар тасалбар болгож улирлын эхний 7 хоногт багтааж улирлын тайлан (ОЭДС-07), хагас жилийн эмчилгээний үр дүнгийн тайлан (ОЭДС-08), жилийн эцсийн эмчилгээний үр дүнгийн тайлан (ОЭДС-10)-г тухайн дүүргийн зохицуулагч эмч гаргаж, дүн бүртгэлийн эмчээр хянуулж ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд илгээнэ.

Тав. Эмчилгээ

ЭДС-ийн эмчилгээний эрчимт шат 6-8 сар, үргэлжлэх шат 12-18 сар, нийт үргэлжлэх хугацаа 18-24 сар байх ба 4-7 төрлийн эм, бэлдмэлийг хослуулан хэрэглэнэ.

5.1 ЭДС-ийн эмчилгээнд хэрэглэх эм, бэлдмэл

Эмийн нэр (эмийн товчлол, эмийн хэлбэр)	Биеийн жинд тохирсон эмийн тун			
	<33 кг	33-50 кг	51-60 кг	>60 кг (дээд тун)
I бүлэг: 1 дүгээр эгнээний ууж хэрэглэх эм				
Изониазид (H) (100, 300 мг шахмал)	4-6 мг/кг/хоногт эсвэл 8-12 мг-р 7 хоногт 3 удаа	200-300 мг/хоногт эсвэл 450-600 мг-р 7 хоногт 3 удаа	300 мг/хоногт эсвэл 600 мг-р 7 хоногт 3 удаа	300 мг/хоногт эсвэл 600 мг-р 7 хоногт 3 удаа
Рифампицин (R) (150, 300 мг шахмал)	10-20 мг/кг/хоногт	450-600 мг	600 мг	600 мг
Этамбутол (E) (100, 400 мг шахмал)	25 мг/кг/хоногт	800-1200 мг	1200-1600 мг	1600-2000 мг
Пиразинамид (Z) (400 мг шахмал)	30-40 мг/кг/хоногт	1000-1600 мг	1600-2000 мг	2000-2400 мг

II бүлэг: Тарилгын бэлдмэл				
Стрептомицин (S) (1 г флакон)	15-20 мг/кг/ хоногт	500-750 мг	1000 мг	1000 мг
Канамицин (Km) (1 г флакон)	15-20 мг/кг/ хоногт	500-750 мг	1000 мг	1000 мг
Амикацин (Am) (1 г флакон)	15-20 мг/кг/ хоногт	500-750 мг	1000 мг	1000 мг
Капреомицин (Cm) (1 г флакон)	15-20 мг/кг/ хоногт	500-750 мг	1000 мг	1000 мг
III бүлэг: Фторхинолоны бүлгийн эм				
Ципрофлоксацин (Cx) (250, 500, 750 мг шахмал)	20-30 мг/кг/ хоногт	1500 мг	1500 мг	1500 мг
Офлоксацин (OfI) (200, 300, 400 мг шахмал)	800 мг	800 мг	800 мг	800-1000 мг
Левифлоксацин (L) (250, 500 мг шахмал)	750 мг	750 мг	750 мг	750-1000 мг
Моксифлоксацин (Mx) (400 мг шахмал)	400 мг	400 мг	400 мг	400 мг
Гатифлоксацин (Gx) (400 мг шахмал)	400 мг	400 мг	400 мг	400 мг
IV бүлэг: 2 дугаар эгнээний ууж хэрэглэх бактериостатик үйлчилгээтэй эм				
Этионамид (Eth) (250 мг шахмал)	15-20 мг/кг/ хоногт	500 мг	750 мг	750-1000 мг
Протионамид (Pto) (250 мг шахмал)	15-20 мг/кг/ хоногт	500 мг	750 мг	750-1000 мг
Циклосерин (Cs) (250 мг капсул)	15-20 мг/кг/ хоногт	500 мг	750 мг	750-1000 мг
Теризадон (Trd) (300 мг шахмал)	15-20 мг/кг/ хоногт	600 мг	600 мг	900 мг
Парааминоса- лицилийн хүчил (PAS) (4 г нунтаг, PASER)	150 мг/кг/хоногт	8 г	8 г	8 г
Тиацетазон	Насанд хүрэгсдэд 150 мг			

5.2 Эмчилгээний горим: ОЭДС-тэй өвчтөнүүдэд эмийн даслын хэлбэрт тохируулан эмчилгээний дараах горимыг сонгоно:

Эмийн даслын хэлбэр	Эмчилгээний горим	Тайлбар
HR-д дасалтай	Z-E-S(Km)*-OfI-Eth	Өмнөх эмчилгээний горим, эмийн таарамжгүй байдал, эмчилгээний үр дүнгээс хамаарч тарилга, фторхинолоны бүлгийн эмийг сольж хэрэглэж болно. Тарилгын бэлдмэлийг доод тал нь 6 сар хэрэглэнэ. Эрчимт шатны эмчилгээний хяналтын өсгөвөрлөх шинжилгээ дараалан 4 удаа сөрөг гарсан тохиолдолд үргэлжлэх шатанд шилжүүлнэ.
HRE-д дасалтай	Z-S(Km)*-OfI-Eth-Cs	
HRS-д дасалтай	Z-E-Km-OfI-Eth(Cs)	
HRES-д дасалтай	Z-Km-OfI-Eth-Cs	

5.3 Бусад эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээг дараах горимоор хийнэ.

Эмийн даслын хэлбэр	Эмчилгээний горим	Үргэлжлэх доод хугацаа (сараар)	Тайлбар
H(±S)	R-Z-E(OfI)	6-9	Хүнд явцтай, сүрьеэгийн өөрчлөлт их үед OfI хэрэглэнэ.
HZ	R-E-OfI	9-12	Хүнд явцтай, сүрьеэгийн тархсан өөрчлөлттэй үед эмчилгээний үргэлжлэх хугацааг уртасгана.
HE	R-Z-OfI	9-12	Хүнд явцтай, сүрьеэгийн тархсан өөрчлөлттэй үед эмчилгээний үргэлжлэх хугацааг уртасгана.
R	H-E-(S)*-OfI-Z**	12-18	*Хүнд явцтай, сүрьеэгийн тархсан өөрчлөлттэй үед тарилгын бэлдмэлээс сонгож хэрэглэнэ. **Z-ыг 2 сараас доошгүй хугацаанд хэрэглэнэ.
Z	3HRSE/6HRE	9	**Тарилгын бэлдмэлийг 2-3 сараас доошгүй хугацаанд хэрэглэнэ.

RE (\pm S)	H-Z-Of-S(Km)**	18	**Тарилгын бэлдмэлийг 2-3 сараас доошгүй хугацаанд хэрэглэнэ. S-ыг 1 сараас дээш хугацаанд хэрэглэсэн эсвэл S-д дасалтай бол Km хэрэглэнэ.
RZ (\pm S)	H-E-OfI-S(Km)**	18	Хүнд явцтай, тархмал сүрьеэгийн үед тарилгын бэлдмэлийг 6 хүртэл сар хугацаанд хэрэглэнэ.
HEZ (\pm S)	R-OfI-Eth-S(Km)**	18	Хүнд явцтай, тархмал сүрьеэгийн үед тарилгын бэлдмэлийг 6 хүртэл сар хугацаанд хэрэглэнэ.

5.4 Эмч нарын зөвлөгөөнөөр эмчилгээний горимыг өөрчлөх асуудлыг шийдвэрлэнэ.

5.5 Өвөрмөц тохиолдлын эмчилгээний горим

- 5.5.1 Жирэмсний эхний 6 сард ОЭДС оношлогдсон тохиолдолд жирэмслэлтийг зогсоох зөвлөмж өгнө. Аминогликозидын бүлгийн эм, Eth-ийг жирэмсэн эхэд хэрэглэхгүй. Жирэмсний сүүлийн хагаст эмчилгээ эхлэх шаардлагатай тохиолдолд Z, Cm, Cs, OfI эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэнэ.
- 5.5.2 Чихрийн шижинтэй өвчтөнд Z, Eth, OfI эмийн бэлдмэлүүдийг хэрэглэхдээ цусан дахь сахарын хэмжээг долоо хоногт 1-2 удаа, креатинин, калийг эмчилгээний эхний сард 7 хоног тутамд, 2 дахь сараас сар бүр хянана.
- 5.5.3 Сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг, согтууруулах ундаа, мансууруулах бодист донтох эмгэгтэй өвчтөнд Cs-ийг хориглож PAS хэрэглэнэ.
- 5.5.4 Элэгний хүнд хэлбэрийн эмгэг, элэгний эмгэгийн сэдрэл даамжирсан үед Eth, R, H эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэж, Z-ийг хэрэглэхийг хориглоно. Эмгэг даамжирч байгаа тохиолдолд элэгний үйл ажиллагааны сорилыг долоо хоногт 1-2 удаа тодорхойлно.
- 5.5.5 Бөөрний дутагдалтай өвчтөнд E, Cm, Eth, Cs эмийн бэлдмэлүүдийг эмчийн хяналтан дор хэрэглэнэ.
- 5.5.6 Шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч, хавсарсан өвчний эмчилгээг хийнэ.

5.6 Эмэнд дасалтай сүрьеэтэй 0-16 насны хүүхдийн эмчилгээ

Эмэнд дасалтай сүрьеэтэй хүүхдийн эмчилгээнд анхаарах зүйл:

- Хүүхдийн жинг сар бүр хянаж, эмийн тунг тохируулан хэрэглэнэ.
- Этамбутолыг 15 мг/кг-аар өдрийн тунг бодно.

5.7 Олон эмэнд дасалтай сүрьеэтэй хүүхдийг эмчлэх 2-р эгнээний эмүүд

Эмийн нэр	Зөвлөмж болгож буй тун	
	Хоногийн тун /мг/кг/	Хоногийн дээд тун /мг/
Этионамид, протионамид	15-20	1000
Фторхинолоны бүлэг <ul style="list-style-type: none"> • Офлоксацин • Левофлоксацин • Моксифлоксацин • Гатифлоксацин • Ципрофлоксацин 	15-207,5-10 7,5-10 7,5-10 20-30	800 - - - 1500
Аминогликозидын бүлэг <ul style="list-style-type: none"> • Канамицин • Амикацин • Капреомицин 	15-30 15-22,5 15-30	1000 1000 1000
Циклосерин буюу Теризидон	10-20	1000
Парааминосалицилийн хүчил	150	12000

5.8 Сүрьеэгийн эмийн гаж нөлөө, түүний эмчилгээ

Сүрьеэгийн эм	Илрэх шинж	Авах арга хэмжээ
Cs, H, S, Km, Am, Cm, Eth/Pto, фторхинолоны бүлгийн эм	Захын мэдрэлийн эмгэг	Пиридоксины тунг 200 мг хүртэл ихэсгэж гаж нөлөө үзүүлж буй эмийн тунг бууруулах буюу хасна. Амитриптилин болон дааврын бус үрэвслийн эсрэг бэлдмэлийг эмчилгээнд хэрэглэнэ.
S, Km, Am, Cm	Сонсгол муудах	Эмчилгээ эхлэхээс өмнө өвчтөн бүрийн сонсголыг аудиометрээр шалгаж эмийн тунг багасгах эсвэл хасна.
Cs, H, фторхинолоны бүлгийн эмүүд	Таталт	Пиридоксины өдрийн тунг 200 мг хүртэл нэмэгдүүлж, таталтын эсрэг эмчилгээ хийнэ.

Cs, H, фторхинолоны бүлгийн эмүүд, Eth/Pto	Сэтгэцийн өөрчлөлт	Сэтгэцийн эмчийн хяналтанд сэтгэц нөлөөт эмээр эмчилж гаж нөлөө үзүүлж буй эмийн тунг бууруулах буюу зогсооно. Сэтгэл гутралын шинж тэмдэг илэрвэл сэтгэл заслын эмчилгээ хийж, сэтгэл гутралын эсрэг бэлдмэлээр эмчлэх, нөлөөлж буй эмийн тунг бууруулах буюу хасна.
PAS, Eth/Pto	Гипотиреоз	Тироксиноор эмчилнэ.
Eth/Pto, PAS, H, E, Z	Дотор муухайрах	Шингэн сэлбэж бөөлжилтийн эсрэг эмээр эмчилж гаж нөлөө үзүүлж буй эмүүдийн тунг бууруулах буюу зогсооно.
PAS, Eth/Pto	Ходоодны үрэвсэл	Антацид, H рецепторын хориг бэлдмэлүүд, бөөлжилтийн эсрэг эм хэрэглэж эмийн тунг бууруулах, 1-7 хоног зогсоох эсвэл бүр мөсөн зогсооно.
Z, H, R, Eth/Pto, PAS, E, фторхинолоны бүлгийн эм	Элэгний үрэвсэл	Эмчилгээг зогсоох, элэгний үрэвсэл үүсгэж байгаа бусад шалтгааныг тогтоож элэг хамгаалах бэлдмэлүүд хэрэглэнэ.
S, Km, Am, Cm	Бөөрний дутагдал	Гаж нөлөө үзүүлж байгаа бэлдмэлийг зогсооно.
Cm, Km, Am, S	Электролитийн тэнцвэр алдагдах (цусан дахь кали ба магнийн хэмжээ буурах)	Шаардлагатай электролитийг нөхнө
E	Харааны өөрчлөлт	Эмийг зогсооно
Z, фторхинолоны бүлгийн эм	Үеэр өвдөх	Үрэвслийн эсрэг стероид бус бэлдмэлүүдийг хэрэглэн биеийн тамир эмчилгээ зөвлөж, эмийг зогсооно.
Cs, H, фторхинолоны бүлгийн эм	Саажилт	Фениитоин, валпроны хүчил уулгана. Пиридоксины тунг 200 мг хүртэл ихэсгэж, нөлөөлж байгаа эмийн тунг бууруулах буюу хасч болно.

5.9 Эмчилгээний хяналт

Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч оношлогдож бүртгэгдсэн өвчтөний биеийн байдал, эмнэл зүйн илрэл, нийгмийн байдал, халдвар хамгааллын эрсдэл зэргийг харгалзан аль шатлалын эрүүл мэндийн байгууллага (тасаг, сум, өрхийн эмнэлэг, өдрийн эмчилгээний цэг, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн)-д шууд хяналттай эмчлэхийг шийдвэрлэнэ.

Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг доорх үндсэн чиглэлийн дагуу хийнэ:

5.9.1 Сүрьеэгийн эмийг шууд хяналттай уулгах

5.9.2 Сүрьеэгийн эмийн гаж нөлөөг хянах

5.9.3 Түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээг эрчимт эмчилгээний шатанд сар тутам, үргэлжлэх шатанд 2 сар тутамд 1 удаа хийх

5.9.4 Гэрлийн шинжилгээг эмчилгээний өмнө болон эрчимт эмчилгээний шатанд 3 сар тутам, үргэлжлэх шатанд 6 сар тутамд хийнэ. Өвчтөний биеийн байдал даамжран хүндэрч байгаа, мэс засал эмчилгээ хийгдэх шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.

5.9.5 Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээ дууссанаас хойш өсгөвөрлөх шинжилгээг 6 сар тутам нийт 5 жил хийнэ.

5.9.6 Цусны дэлгэрэнгүй, шээсний ерөнхий шинжилгээг эмчилгээний өмнө болон эрчимт эмчилгээний шатанд 3 сар тутам, үргэлжлэх шатанд 6 сар тутамд хийнэ. Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.

5.9.7 Цусанд кали, натри, креатинин, мочефин, билирубин, трансминазаг эмчилгээний өмнө болон эрчимт эмчилгээний шатанд сар тутамд, үргэлжлэх шатанд өвчтөний биеийн байдлаас хамаарч 3-6 сар тутамд тодорхойлно.

5.9.8 Бамбайн дааврын идэвхжүүлэгч гормон (ТСГ)-ыг эмчилгээний эхэнд, шаардлагатай тохиолдолд хугацаа хамаарахгүй тодорхойлно. Эмчилгээнд Eth/Pto хэрэглэж буй үед 6 сар тутамд тодорхойлно.

5.9.9 Хараа, сонсголыг эмчилгээний өмнө болон эрчимт эмчилгээний шатны төгсгөлд шалгана.

5.9.10 Эмчилгээний явцад өвчтөнийг үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар ХДХВ илрүүлэх шинжилгээнд хамруулна.

5.9.11 Өвчтөний биеийн жинг эмчилгээний явцад сар тутам хянана.

5.9.12 Эмчилгээ дууссанаас хойш 5 жилийн туршид жилд нэгээс доошгүй удаа гэрлийн шинжилгээ болон эмнэлзүйн хяналт хийнэ.

5.9.13 ЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөнөөр эмчилгээний 6, 12, 18, 24 дэх саруудад, биеийн байдал хүнд, гаж нөлөө ихтэй тохиолдолд хугацаа харгалзахгүй оруулна.

5.10 ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний хяналт

	Өрх, сумын эмнэлэг	Сайн дурын идэвхтэн	Сүрьеэгийн диспансер	Өдрийн эмчилгээний цэг	Сүрьеэгийн клиник, хорих 429-р ангийн эмнэлэг	
					ОЭДС-ийн тасаг	Эрчимт
Эмчилгээний шат	Үргэлжлэх	Үргэлжлэх	Эрчимт, үргэлжлэх	Эрчимт, үргэлжлэх	Эрчимт	Шинж тэмдгийн
Эмчилгээ үргэлжилэх хугацаа	12-18 сар	12-18 сар	18-24	Эрчимт шат 6-8 сар, Үргэлжлэх шатанд 3 сар	4-8 сар	14 хоног хүртэл
Нян судлалын шинжилгээ	Сөрөг	Сөрөг	Эерэг, сөрөг	Эерэг, сөрөг	Эерэг, сөрөг	Эерэг, сөрөг
Клиник илрэл	Дунд	Дунд	Дунд	Дунд	Хүнд	Маш хүнд
Гаж нөлөөний илрэл	Бага	Бага	Бага	Их, бага	Их, бага	Их, бага
Хавсарсан өвчин	Байхгүй	Байхгүй	Байхгүй, сэдэрлгүй	Байхгүй, Хавсарсан өвчний сэдэрл, идэвхжлийн үе	Хавсарсан өвчний сэдэрл, идэвхжлийн үе	Хавсарсан өвчний сэдэрл идэвхжил эзэнгшилгүй үе
Хүндрэл	Байхгүй	Байхгүй	Хордлого багатай	Хордлого багатай	Хордлого багатай	Амин чухал эрхтнүүдийн хүнд хэлбэрийн дутагдалтай, амьсгал зүрх судасны III зэргийн дутагдалтай

Зургаа. Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх журам

Үндэсний болон аймгийн түвшинд эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр ЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.

6.1 Үндэсний түвшин дэх эмч нарын зөвлөгөөний бүрэлдэхүүн

Дарга - ХӨСҮТ-ийн ЭТҮЭ дэд захирал
Нарийн бичиг - ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга
Гишүүд:

- НЭМГ-ын халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн зөвлөх эмч
- ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач их эмч
- ХӨСҮТ-ийн ОЭДС-ийн тасгийн эрхлэгч болон эмчлэгч эмч
- Дүрс оношлогооны эмч
- Сүрьеэгийн лавлагаа лабораторийн тасгийн эрхлэгч
- Эм хариуцсан хяналтын эмч
- Харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч
- Шаардлагатай тохиолдолд бусад нарийн мэргэжлийн эмч нарыг зөвлөгөөнд оролцуулна.

Дээрх бүрэлдэхүүнтэй эмч нарын зөвлөгөөнийг сард 2-3 удаа зохион байгуулна.

6.2 Аймгийн түвшин дэх эмч нарын зөвлөгөөний бүрэлдэхүүн

Дарга - Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга
Нарийн бичиг - Сүрьеэгийн зохицуулагч эмч
Гишүүд:

- Чанарын менежер
- Сүрьеэгийн эмч нар
- Аймгийн ЭМГ-ын тархвар судлаач их эмч
- Дүрс оношлогооны эмч
- Шаардлагатай тохиолдолд бусад нарийн мэргэжлийн эмч нарыг зөвлөгөөнд оролцуулна.

Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлаар

дээрх бүрэлдэхүүнтэй эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж шаардлагатай тохиолдолд ХӨСҮТ-ийн нарийн мэргэжлийн эмчээс мэргэжил арга зүйн зөвлөмж авна.

6.3 Өвчтөнийг зөвлөгөөнд оруулахад бүрдүүлэх материал

6.3.1 Заавал хийгдэх шинжилгээ:

- өсгөвөр, эмийн мэдрэг чанар тодорхойлох
- түрхэцийн шинжилгээ
- гэрлийн шинжилгээ
- цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- элэгний үйл ажиллагааны сорил
- шээсний ерөнхий шинжилгээ
- бамбай булчирхайн дааврын шинжилгээ
- хараа зүйн үзлэгийн дүгнэлт
- сонсголын бичлэг
- төрөх насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил

6.3.2 Өвчний түүхийн болон холбогдох шинжилгээний хариуг бичсэн танилцуулга

6.3.3 Өвчтөний хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэгт оруулсан мэдээлэл

6.3.4 Эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд оруулахад өвчтөн болон гэр бүлийн гишүүн нь ЭДС-ийн эмчилгээ хийлгэхийг зөвшөөрсөн, тодорхой харьяалалтай байх шаардлагатай.

6.4 Эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээний эсрэг заалт:

- Сүрьеэ өвчний улмаас уушгинд эргэшгүй, их хэмжээний бүтцийн өөрчлөлт гарсан
- Амьдралын чухал эрхтэнүүд (Зүрх судас, амьсгал, элэг, бөөр)-ийн хүнд хэлбэрийн дутагдалтай
- Сэтгэцийн хүнд хэлбэрийн өвчин, эмгэгтэй
- Өвчтөн, түүнийг асран хамгаалагч болон ар гэрийнхэн эмчилгээнээс татгалзсан
- Сүрьеэгийн эсрэг 2-р эгнээний эмийг удаан хугацаагаар хэрэглэсэн боловч цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян эерэг хэвээр байх

6.5 ЭДС-ийн тасгаас өвчтөнг гаргах заалт

- Өсгөвөрлөх шинжилгээ дараалан 2 удаа сөрөг болсон
- Түрхэцийн шинжилгээ сөрөг болсон
- Эмийн зохимж сайн, гаж нөлөө бага
- Биеийн байдал дунд, эмнэлзүйн сайжрал өгсөн
- Гэрлийн шинжилгээний динамик сайжралтай
- ЭДС-ийн тасагт 4-6 сар эмчлэгдсэн
- ЭДС-ийн тасагт 8 сар эмчлүүлсэн боловч сөрөгт шилжээгүй хүнд тохиолдол

Долоо . Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд хамрагдах тухай зөвшөөрлийн хуудас

7.1 Өвчтөний мэдээлэл

Овог

Эцэг /эх/-ийн нэр

Нэр

Төрсөн огноо / /
он / сар / өдөр

Регистрийн дугаар

Гэрийн хаяг

Эмчлэгч эмчийн нэр
 албан тушаал

Хүйс эрэгтэй эмэгтэй

Тэмдэглэл

7.2 Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээний талаарх мэдээлэл

Сүрьеэ нь Mycobacterium tuberculosis нянгаар үүсгэгддэг, хүнээс хүнд амьсгалын замаар халдварладаг, архаг явцтай нийгмийн халдварт өвчин юм. Сүрьеэтэй өвчтөн ханиах, найтаах,

цэрээ хаях, ярих, дуулах зэрэгт нян агаарт цацагдан эргэн тойронд байгаа хүмүүст халдвар тараадаг.

Сүрьеэгийн эсрэг эмүүдэд дасалтай болсон сүрьеэг эмэнд дасалтай сүрьеэ гэнэ. Эмчилгээний явцад өвчтөн эмийг тогтмол уугаагүй, эмчилгээг бүрэн хийлгээгүй тохиолдолд эмэнд дасалтай сүрьеэ үүсдэг.

Олон эмэнд дасалтай сүрьеэ нь эмчлэгдэхэд төвөгтэй бөгөөд 18-24 сар буюу түүнээс дээш хугацааны эмчилгээ шаардагддаг. Эхний 6 сараас доошгүй хугацааг эмчийн хяналт дор эмнэлэгт тусгаарлагдан эмчлүүлэх бөгөөд халдваргүй болсон үедээ диспансераар 18 сараас доошгүй хугацаагаар дор хаяж 5 төрлийн эм, тариаг хавсран хэрэглэх буюу өдөрт 15-25 ширхэг эм ууж, 6 сар буюу түүнээс удаан хугацаагаар тариа хийлгэдэг.

Хэрэв өвчтөн эмчилгээг өдөр бүр тогтмол хийлгэхгүй эсвэл эмчилгээг бүрэн дуусгаагүй тохиолдолд эмчилгээнд хэрэглэсэн эмүүдэд дахин дасалтай болж, өвчин даамжран хүндэрч, улмаар амь насанд аюул учруулдаг.

Эмчилгээний явцад дотор муухайрах, огиулах, бөөлжих, үе мөчөөр өвдөх, булчин сулрах, нойр хоолонд муудах, толгой өвдөх, дүйнгэтэх, хараа, сонсгол муудах, сэтгэл гутрах, харшлын урвал өгөх зэрэг гаж нөлөө гардаг. Ховор тохиолдолд таталт өгөх, хий юм харах, солиорох шинжүүд гарч болдог. Ийм үед гаж нөлөө үүсгэж байгаа эмийн бэлдмэлийн тунг бууруулах буюу хасах, гаж нөлөөний эсрэг эмчилгээ хийнэ.

Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээ нь өртөг өндөртэй хэдий ч таныг зөвхөн нэг удаа үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулах боломж олгогдсон гэдгийг анхаарна уу.

Хэрэв өвчтөн эмээ өдөр бүр уухгүй байх, эмчилгээгээ таслах, эсвэл цогц эмчилгээнд үр дүн гарахгүй байвал эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр эмчилгээг зогсооно.

Эмчийн гарын үсэг 20 ____/____/____

Эмчийн нэр
(гаргацтай бичнэ үү)

Албан тушаал

7.3 Өвчтөний мэдэгдэл

Би олон эмэнд дасалтай сүрьеэ, түүний эмчилгээний талаарх

мэдээллийг бүрэн уншиж танилцлаа. Би асуусан бүх асуултанд хангалттай хариулт авсан.

1. Миний бие

- Бусдад нэн халдвартай,
- Эмчлэгдэхэд төвөгтэй,
- 18-24 сар буюу түүнээс дээш хугацааны эмчилгээ шаардагддаг олон эмэнд дасалтай сүрьеэгээр өвчилсөн тухай эмчээс мэдээлэл авсан.

2. Би эдгэрэхийн тулд

- Эмч нарын шууд хяналтанд эмнэлэгт дунджаар 4-6 сар тусгаарлагдан эмчлүүлж, үргэлжлэх шатанд диспансераар 18 сараас доошгүй хугацаагаар эмийг тасралтгүй ууна.
- Өдөрт 15-25 ширхэг эмийг ууж, удаан хугацаагаар тариа хийлгэнэ.
- Эмчилгээний явцад гаж нөлөө үүсэх боломжтой бөгөөд энэ тохиолдолд гаж нөлөөний эсрэг эмчилгээ хийлгэнэ.

3. Хэрэв би эмчилгээгээ бүрэн төгс хийлгэхгүй бол

- Эмчилгээнд хэрэглэсэн эмүүдэд дахин дасалтай болж, өвчин даамжран хүндэрч, улмаар амь насанд аюул учрах
- Ханиах, найтаах, цэр хаях, ярих, дуулах зэрэгт нян агаарт цацагдан, эргэн тойронд байгаа ойр дотны хүмүүстээ амьсгалын замаар халдвар тараах зэрэг аюултай болохыг ойлгож байна.

4. Хэрэв би эмчийн заавраар эмчилгээг тогтмол тууштай хийлгэвэл

- Бусдад халдвар тараахгүй болж, миний өвчин эдгэрнэ.
Миний бие _____

Өвчтөн өөрөө бичнэ: *Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд хамрагдаж, эмчийн зааврын дагуу эмчилгээнд заагдсан бүх эмийг тогтмол хэрэглэхийг зөвшөөрч байна. Хэрэв эмийг тогтмол хэрэглэхгүй байх эсвэл эмчилгээг тасалсан тохиолдолд эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр эмчилгээг зогсоож, эмчилгээнд дахин хамрагдах боломжгүй болоход гомдолгүй.*

Өвчтөний эцэг/эх/-ийн нэр, нэр 20 ____/____/____
гарын үсэг
Эцэг/эх/асран хамгаалагч/
ар гэрийн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр ... 20 ____/____/____
гарын үсэг

Эрүүл мэндийн сайдын 2009 оны сарын...
өдрийнтоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдварын үеийн тусламж үйлчилгээний удирдамж

Сүрьеэ ХДХВ-ийн хавсарсан халдвартай тохиолдолд сүрьеэ өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, бүртгэн мэдээлэх үйл ажиллагааны хүрээнд энэхүү удирдамжийг мөрдлөг болгоно. Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан, ХДХВ-ийн халдваргүй тохиолдолд сүрьеэгээр өвчлөх эрсдэл 5-10% байдаг бол, ХДХВ-ийн халдвартай тохиолдолд энэ эгзэг 50% хүрдэг байна.

Нэг. Илрүүлэлт

Сүрьеэтэй бүртгэгдсэн, ХДХВ/ДОХ-той тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар үзлэг шинжилгээ хийнэ.

1.1 ХДХВ-ийн халдвар илрүүлэх зөвлөгөө, шинжилгээ хийх:

- 1.1.2 Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн бүх тохиолдол
- 1.1.3 Сүрьеэгийн эмчилгээний 6 дахь сард
- 1.1.4 Давтан бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдол
- 1.1.5 Эмэнд дасалтай сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол 6 сар тутам
- 1.1.6 Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнд ХДХВ-ийн халдварын шинж тэмдэг илэрвэл

1.2 Сүрьеэ илрүүлэх шинжилгээ хийх:

- 1.2.1 ХДХВ/ДОХ шинээр оношлогдсон тохиолдолд, цаашид 6 сар тутамд
- 1.2.2 ХДХВ/ ДОХ-той тохиолдолд сүрьеэгийн сэжигтэй шинж илэрсэн үед

Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар гэдэг нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдээлэл үйлчлүүлэгчдэд өгсний дараа ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд илгээх, хариу гарсны дараа давтан зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

Хоёр. Тохиолдлын тодорхойлолт

2.1 Түрхэц эерэг уушгины сүрьеэ

ХДХВ-ийн халдвартай нь лабораториор батлагдсан эсвэл ХДХВ-ийн халдвар байж болзошгүй эмнэлзүйн шинжүүд илэрсэн, цэрний түрхэцийн шинжилгээгээр нэг ба түүнээс дээш сорьцонд хүчилд тэсвэртэй нян эерэг тохиолдол

2.2 Түрхэц сөрөг уушгины сүрьеэ


ХДХВ-ийн халдвартай болох нь лабораториор батлагдсан буюу ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн шинжүүд тод илэрсэн, цэрний түрхэцийн шинжилгээгээр 2-оос доошгүй сорьцонд хүчилд тэсвэртэй нян сөрөг, гэрлийн шинжилгээнд идэвхитэй сүрьеэгийн өөрчлөлт илэрсэн эсвэл түрхэц сөрөг, өсгөвөр эерэг тохиолдол

2.3 Уушгины бус эрхтэний сүрьеэ

ХДХВ-ийн халдвар лабораториор баталгаажсан эсвэл ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн шинжүүд тод илэрсэн, уушгинаас бусад эрхтэнээс авсан сорьцонд сүрьеэгийн гаралтай үрэвсэл үүссэн нь эд эс, нян судлалын шинжилгээний аль нэг баталгаажсан тохиолдол

Гурав. Оношлогоо

3.1 ХДХВ-ийн халдвартай хүнд сүрьеэг оношлох алгоритм



3.2 Уушгины сүрьеэгийн оношлогоо

3.2.1 Эмнэл зүйн шинж тэмдэг

- ХДХВ-ийн халдварын эрт үед сүрьеэ ердийн байдлаар илэрч, голдуу уушгины дээд дэлбэнд өөрчлөлт үүснэ.
- Дархлал дутал гүнзгийрэх тусам анхдагч сүрьеэ, уушгины бус эрхтэний болон тархмал сүрьеэтэй төстэй шинжүүд илэрч уушгины угийн тунгалгийн булчирхай, уушгины доод дэлбэн гэмтдэг.

-
- Сүрьеэ, ХДХВ-ийн халдвар хавсарсан өвчтөнд халуурах, биеийн жин буурах, хөлрөх шинжүүд элбэг тохиолдоно. ХДХВ-ийн халдвартай өвчтөний эсийн дархлал буурсантай холбоотой гуурсан хоолойн доторх цочрол бага байдгаас ханиалгах шинж бага илэрнэ.

3.2.2 Эмнэл зүйн оношлогоо

- ХДХВ-ийн халдварын эрт, дархлалын тогтолцооны өөрчлөлт бага, CD4 эсийн хэмжээ 200/мм-ээс дээш үед сүрьеэтэй өвчтөнд эмнэлзүй болон цээжний гэрлийн шинжилгээний өөрчлөлт ХДХВ-ийн халдваргүй хүнтэй ижил илэрнэ. Харин CD4 эсийн хэмжээ 200/мм-ээс бага үед уушгины сүрьеэгийн хэв шинжит бус эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрнэ.
- ХДХВ-ийн халдвар сүрьеэтэй хавсарсан тохиолдолд илрэх эмнэл зүйн онцлог:
- Уушгины бус эрхтэний сүрьеэ зонхилж үүснэ. Тунгалгийн булчирхайн сүрьеэ тэр дундаа хүзүүний тунгалгийн булчирхайн сүрьеэ элбэг тохиолдоно.
- Хурц тархмал сүрьеэгийн хувь ихэснэ.
- ХДХВ-ийн халдварын сүүлийн шатанд сүрьеэгийн улмаас голтын тунгалгийн булчирхай томорсон, гялтангийн болон үнхэлцэг хальсанд шингэн хуримтлагдсан шинж илэрнэ. Уушгинд задрал явагдах нь ховор.
- Сүрьеэгийн өөрчлөлт хэвийн бус байрлалтай болно. Тархины туберкулем, цээжний хэнхэрцэгийн буглаа тохиолдоно.
- Халуурах, турах, хөлрөх шинж давуу илэрнэ.

3.2.3 Лабораторийн оношлогоо

Эмнэл зүйн оношлогоонд илэрсэн өөрчлөлтийг батлах зорилгоор үндсэн болон туслах шинжилгээ хийнэ.

- Нян судлалын шинжилгээ
Сүрьеэ, ХДХВ-ийн халдвар хавсарсан үед цэрний түрхэцийн шинжилгээ сөрөг байх нь элбэг тул өсгөвөрлөх шинжилгээ хавсран хийнэ. Хурц тархмал сүрьеэтэй өвчтөний цусны өсгөвөрт сүрьеэгийн нян ургаж болно.
- Туберкулины сорил
ХДХВ-ийн халдвартай сүрьеэтэй өвчтөнд дархлалын эсүүд цөөрсөнтэй холбоотойгоор туберкулины арьсны сорил сөрөг гарч болно.
- Цээжний гэрлийн шинжилгээ
ХДХВ-ийн халдвартай, уушгины сүрьеэгийн сэжигтэй шинж

илэрсэн, цэрний түрхэц сөрөг, өргөн хүрээний антибиотик эмчилгээ үр дүнгүй тохиолдолд цээжний гэрлийн шинжилгээ хийнэ. ХДХВ-ийн халдвартай хүнд бусад нянгаар үүсгэгдсэн гуурсан хоолой, уушгины үрэвсэл элбэг тохиолддог тул сүрьеэгийн өөрчлөлтийг ялган оношлох шаардлагатай. Сүрьеэтэй тохиолдолд хөндий, оройн хэсгийн байрлал, уушгины сорвижилт, агчилт, шохойжилт зэрэг өвөрмөц шинж байдаг ч дан гэрлийн шинжилгээний өөрчлөлтөөр оношлох нь хүндрэлтэй. Дархлал доройтох тусам цээжний гэрлийн шинжилгээнд уушгины доод дэлбэн, цээжний хөндийн тунгалгийн булчирхайн гэмтэл илэрнэ.

3.3 Уушгины бус эрхтэний сүрьеэгийн эмнэл зүй

ХДХВ-ийн халдвартай, сүрьеэтэй тохиолдолд уушгины бус эрхтэний сүрьеэ зонхилон тохиолддог байна.

3.3.1 Уушгины бус эрхтэний сүрьеэгийн эмнэл зүйн онцлог:

- Тухайн эрхтэний үйл ажиллагааны өөрчлөлттэй холбоотой эмнэл зүйн шинжээс гадна халуурах, хөлрөх, биеийн жин алдагдах зэрэг шинж тэмдэг илэрнэ.

3.3.2 Уушгины бус эрхтэний сүрьеэгийн эмнэл зүйн оношлогоо
Эмнэл зүйн шинж илэрсэн өвчтөний эмгэгтэй эрхтэнээс авсан сорьцонд эд эс, нян судлалын шинжилгээний аль нэгээр оношийг батална. Тухайн эрхтэн системийн үйл ажиллагааны болон бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх нэмэлт шинжилгээ хийнэ.

3.3.3 Уушгины бус сүрьеэгийн ялган оношлогоо

	Закны тунгалагийн бүлчирхийн сүрьеэ	Цэвэрлэгдсэн хальсны шүүдэст урвасал	Тархмал сүрьеэ	Үнэлцдэг хальсны шүүдэст урвасал	Сүрьеэгийн менингиг
Шаардлагатай шинжилгээ	<ul style="list-style-type: none"> ХДХВ-ийн шинжилгээ Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Бүлчирхийлдэг хатгалт хийж ХТН илрүүлэх 	<ul style="list-style-type: none"> ХДХВ-ийн шинжилгээ Цэвэрлэгдсэн хальсны шинжилгээ Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Хатгалт хийж авсан шингэнд цагаан эс тоолох, уураг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> ХДХВ-ийн шинжилгээ Цэвэрлэгдсэн хальсны шинжилгээ Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Цуны өсгөвөр. Цуны дэлгэрэнгүй шинжилгээ. Криптококкын антиген Турах, хөлрөх, халуургах шинжүүд Цус салгадаг Эзлэг, долоу гомрох Цэвэрлэгдсэн хальсанд шар будаа мэт өөрчлөлт илрэх 	<ul style="list-style-type: none"> ХДХВ-ийн шинжилгээ Цэвэрлэгдсэн хальсны шинжилгээ Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Зүрхний ЭХО Зүрхний цахилгаан бүчлэг Уушгины өөрчлөлтгүй, 2 удаах турхацин ялган шүүдэст урвасал Турах, хөлрөх, халуургах шинжүүд Турах, хөлрөх, халуургах шинжүүд Уушгины өөрчлөлтгүй, 2 удаах турхацин ялган шүүдэст урвасал Турах, хөлрөх, халуургах шинжүүд Бусад эрхтэний сүрьеэ 	<ul style="list-style-type: none"> ХДХВ-ийн шинжилгээ Цэвэрлэгдсэн хальсны шинжилгээ Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Тархи нугасны шингэнд тодорхойлох Турах, хөлрөх, халуургах шинжүүд Турах, нугасны шингэн урвасал, уураг ихэвчлэн Ханиалгаж байгаа бол цэрний турхацин шинжилгээ Бусад эрхтэний сүрьеэ Тархи нугасны шингэнд криптококкын эсрэг бие сэрэг Нягтийн гаралтай өвчний уед тархи нугасны шингэн бүлчирхтэй, нейтрофиль тодорхойлогдоно Хурц эхлэлтэй Тархи нугасны шингэн маш өндөр даралттай Криптококк нян шинжилгээнд эерэг
Сүрьеэ байж болохгүй шинж тэмдэг	<ul style="list-style-type: none"> 2 см болон түүнээс дээш шилээж Нэг тал, хэсэг гарын Эмзглэлтэй, хавчгасан Өвчлэн, (доорсон) хатуу Хурууны ар-ор, үүдгүй Салдсан булчирхайн бүлчирхайнүүд төмөрч болж буй бүлчирхайнүүд томорч болж буй бүлчирхайнүүд Турах, шөнө хөлрөх, халуургах шинжүүд 	<ul style="list-style-type: none"> Аль нэг талын урвасал Шингэн, - тунгалаг, сүрлэн ширдэг өнгөтэй Эзлэг, долоу гомрох шингэнд, барьцалдах нөхцөх Турах, хөлрөх, халуургах шинжүүд Бусад эрхтэний сүрьеэ 	<ul style="list-style-type: none"> Чирүүдэс хүрэх Маш их амьсгаадах Сулгах Баас цусгай гарах Цуны өсгөвөрт өөр төрлийн нян ургах 	<ul style="list-style-type: none"> Зүрхний дутагдлын үед Уушгины галбайд, үечлсэн сүүдэрлэг, зүрхний хэлбэр зөв бус Цуны даралт өндөр Зүрхний цахилгаан бүчлэгт өөр өвчний улмаас зүрх томорсон шинжтэй Хавхлагын өөрчлөлийн үед муурын хэржилтээ Нягтийн гаралтай үнэлцлэг хальсны урваслийн үед чирүүдэс хүрэх 	<ul style="list-style-type: none"> Нягтийн гаралтай өвчний уед тархи нугасны шингэн бүлчирхтэй, нейтрофиль тодорхойлогдоно Хурц эхлэлтэй Тархи нугасны шингэн маш өндөр даралттай Криптококк нян шинжилгээнд эерэг
Сүрьеэгийн бус шинжүүд	<ul style="list-style-type: none"> Арьс, амны, Капошийн саркома Пифром, зээл ХДХВ-ийн лимфаденопати нь 2 талд тэлж хэлтэй Мөөгөнцөр болон нянгийн хадварын үед хатуу тогтоцтой, улайж хавдсан, идэвхсэн Хурунзас бусад тунгалагийн бүлчирхай 	<ul style="list-style-type: none"> Хатгалгаа зүрхний дутагдлын үед 2 талын урвасал Капошийн саркома Бусад хадвар Шингэн, бохир, идээтэй, эмлсэн Зүрхний дутагдлын үед нөмгирч, бүлээгнэхүй гэхдээ энэ нь сүрьеэг үгүйсгэхгүй 	<ul style="list-style-type: none"> Чирүүдэс хүрэх Маш их амьсгаадах Сулгах Баас цусгай гарах Цуны өсгөвөрт өөр төрлийн нян ургах 	<ul style="list-style-type: none"> Зүрхний дутагдлын үед Уушгины галбайд, үечлсэн сүүдэрлэг, зүрхний хэлбэр зөв бус Цуны даралт өндөр Зүрхний цахилгаан бүчлэгт өөр өвчний улмаас зүрх томорсон шинжтэй Хавхлагын өөрчлөлийн үед муурын хэржилтээ Нягтийн гаралтай үнэлцлэг хальсны урваслийн үед чирүүдэс хүрэх 	<ul style="list-style-type: none"> Нягтийн гаралтай өвчний уед тархи нугасны шингэн бүлчирхтэй, нейтрофиль тодорхойлогдоно Хурц эхлэлтэй Тархи нугасны шингэн маш өндөр даралттай Криптококк нян шинжилгээнд эерэг
Нэн даруй авах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Шингэний сорулж шитологи, турхацин шинжилгээнд илгээх доорхи томилолдоос бусад үед биоси авч ХДХВ-ийн хадвартай хүн тархмал сүрьеэгээр хүчдрэх эрсдэлтэй Сүрьеэ байх эмгэглүүн шинж, тод, биосийн харку хүлгээх боломжгүй 	<ul style="list-style-type: none"> Сүрьеэ оношлогдвол эмчилгээ эхлэх Шингэнд эс тоолох, уураг тодорхойлох, боломжтой бол шитологи шинжилгээнд явуулах 	<ul style="list-style-type: none"> Сүрьеэгийн эмчилгээ эхлэх Амьсгадалт маш их байвал шингэний сорулж Бусад шалтгааныг хайх Хэт авиалаар шүүдэс байгааг баталсан, 7 хоногт өөр онош тогтоогдожгүй бол сүрьеэгийн эмчилгээ эхлэх 	<ul style="list-style-type: none"> Сүрьеэгийн илрэлтэй Сүрьеэгийн эмчилгээ эхлэх Амьсгадалт маш их байвал шингэний сорулж Бусад шалтгааныг хайх Хэт авиалаар шүүдэс байгааг баталсан, 7 хоногт өөр онош тогтоогдожгүй бол сүрьеэгийн эмчилгээ эхлэх 	<ul style="list-style-type: none"> Сүрьеэгийн илрэлтэй Сүрьеэгийн эмчилгээ эхлэх Амьсгадалт маш их байвал шингэний сорулж Бусад шалтгааныг хайх Хэт авиалаар шүүдэс байгааг баталсан, 7 хоногт өөр онош тогтоогдожгүй бол сүрьеэгийн эмчилгээ эхлэх Криптококкын сэрлэг, ХДХВ-ийн хадвартай, өөр өвчний онош тавигдаагүй бол криптококкын эсрэг эмчилгээ хийнэ

Дөрөв. Эмчилгээ

4.1 Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдвартай өвчтөнд сүрьеэгийн эмчилгээг энгийн тохиолдолтой адил горимоор эмчилж хянана.

4.2 Сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдварын үеийн ретровирүсийн эсрэг эмчилгээг доорх зарчмаар хийнэ.

CD 4 эсийн тоо (эс/мм ³)	РВЭЭ эхлэх зөвлөмж	РВЭЭ хавсарч хийх хугацаа
350-аас бага	РВЭЭ эхлэхийг зөвлөнө	2-8 долоо хоногийн дотор
350-аас дээш	РВЭЭ эхлэхийг хойшлуулна	8 долоо хоногийн дараа, сүрьеэгийн эмчилгээний төгсгөлд эмнэл зүйн болон лабораторийн үнэлгээ хийх
Уушгины бус эрхтэний сүрьеэгийн үед CD4 эсийн тоог харгалзахгүй	РВЭЭ эхлэхийг зөвлөнө	2-8 долоо хоногийн дотор
ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн 4-р үе шат	РВЭЭ эхлэхийг зөвлөнө	2-8 долоо хоногийн дотор
CD4 тоолох боломжгүй үед	РВЭЭ эхлэхийг зөвлөнө	8-8 долоо хоногийн дотор

4.3 Сүрьеэтэй өвчтөн ХДХВ/ДОХ-той болох нь тогтоогдсон үед котримоксазолын урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх заалт

4.3.1 CD4 эсийн тоо 200 эс/мм³-ээс бага буюу эмнэлзүйн 3, 4-р үе шатанд CD4 эсийн түвшинг харгалзахгүйгээр хийнэ. РВЭЭ эхлэхээс өмнө котримоксазолын урьдчилан сэргийлэх эмчилгээг 2 долоо хоногийн турш хийж харшлын шинж илрэхгүй тохиолдолд ретровирүсийн эсрэг эмчилгээг эхэлнэ.

4.3.2 CD4 тоолох боломжгүй үед сүрьеэтэй бүх өвчтөнд котримоксазолын анхдагч урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.

4.3.3 Котримоксазолын урьдчилан сэргийлэх эмчилгээний тун: Өсвөр насныхан болон насанд хүрэгчдэд өдөрт нэг удаа 2 шахмалыг хэрэглэнэ. Хоногийн тун: 960 мг сульфаметоксазол (СМЗ) + 160 мг триметоприм (ТМП). Сульфаниламидийн бүлгийн эмэнд харшилтай өвчтөнд дапсоныг өдөрт 100 мг-аар өгнө.

4.4 Эмэнд дасалтай сүрьеэ, ХДХВ-ийн хавсарсан халдвар ХДХВ-ийн халдвартай тохиолдол эмэнд дасалтай сүрьеэгээр өвчилсөн бол оношлогоо, эмчилгээ нь энэ тушаалын гуравдугаар хавсралтын дагуу хийгдэнэ.

Тав. Эмчилгээний хяналт

- 5.1 Хүнд хэлбэрийн болон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эрчимт шатны эмчилгээг эмнэлэгт, үргэлжлэх шатны эмчилгээг сүрьеэгийн диспансерийн эмчийн шууд хяналтанд хийнэ.
- 5.2 РВЭЭ-г харьяа аймаг, дүүргийн ХДХВ/БЗДХ-ын эмчийн хяналтанд, ЭДС-тэй өвчтөний РВЭЭ-г ДОХ/БЗДХ-ын мэргэжлийн эмчийн зөвлөгөө, хяналтын дагуу эрчимт шатны хугацаанд ЭДС-ийн тасагт, үргэлжлэх шатны эмчилгээний үед ДОХ/БЗДХ-ын мэргэжлийн эмчийн хяналтанд хийнэ.
- 5.3 Эмчилгээний хяналтын цэрний түрхэц, өсгөвөрлөх шинжилгээг энэ тушаалын хоёр, гуравдугаар хавсралтын дагуу хийнэ.

Сүрьеэгийн эм, урвалж бодисын менежментийн удирдамж

Сүрьеэгийн эм, урвалж бодисыг захиалах, хадгалах, хуваарилах, тээвэрлэх, зарцуулах, үр дүнг тооцох, эмийн зохистой хэрэглээг хянах үйл ажиллагаанд энэ удирдамжийг мөрдөнө.

Нэг. Эм, урвалж бодисын захиалга

Сүрьеэгийн I, II эгнээний эм, эмэнд дасалтай сүрьеэгийн гаж нөлөөний эм, урвалж бодисын захиалгыг жил бүрийн 1-р улиралд багтаан өмнөх оны өвчлөлийн байдал, хийгдсэн шинжилгээний тоо, байвал зохих нөөцийг үндэслэн улсын хэмжээнд шаардлагатай эм, урвалж бодисын хэрэгцээг тооцож захиална.

Хоёр. Эм, урвалж бодис хүлээн авах

- 2.1 ХӨСҮТ-ийн захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг сүрьеэгийн эм, урвалж бодисыг хүлээн авч, чанарын баталгаажилт, савлалт, бүрэн бүтэн байдал, бохирдол зэргийг шалган тэмдэглэл хөтлөнө.
- 2.2 Хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгслийн савлалт нь гэмтсэн, чанарын баталгаажилтгүй, захиалгад тохироогүй, дагалдах бичиг баримтгүй бол “түр хүлээлгэнд байгаа” гэж хаяглан асуудлыг шийдвэрлэх хүртэл тусгаарлан хадгална
- 2.3 Эмийн чанарыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулж дүгнэлт гаргуулна.
- 2.4 Хүлээн авсан эм, урвалж бодисыг Сүрьеэгийн тандалт, судалгааны албаны эмийн болон лабораторийн агуулахад байршуулна.

Гурав. Эм хадгалах өрөөнд тавигдах шаардлага

- 3.1 Агуулахын хаалга, цонх нь зай завсаргүй, бат бөх хамгаалалттай, хана, таазны дотор гадаргуу нь цайвар өнгөтэй, гөлгөр, чийгтэй цэвэрлэгээ хийх боломжтой, шал нь тоос гаргадаггүй, гэрэл, халдваргүйжүүлэх бодисын

-
- нөлөөнд тэсвэртэй материалаар хийгдсэн, хортон шавьж, мэрэгчгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.
- 3.2 Цонх нь нарны гэрэл нэвтрүүлдэггүй халхавчтай, агаарын солилцоо хангалттай явагдах нөхцөлтэй, салхивч нь чөлөөтэй хаагдаж нээгддэг, шороо тоос орохоос хамгаалагдсан, агаар солилцооны төхөөрөмжөөр тоноглогдсон, 150С-ээс 200С-ийн дулаантай, харьцангуй чийглэг 20% -60% байна.
- 3.3 Чийг, дулаан хэмжигчийг халаах хэрэгслээс хол, шалнаас 1.5-1.7 м-ийн өндөрт, хаалганаас 3 м-ээс багагүй зайд байрлуулан өдөр бүр хянаж бүртгэл хөтөлнө.
- 3.4 Эм хадгалах тавиурыг хана, таазнаас 0.5 м, шалнаас 0.3 м, цонх, халаагуураас 0.75 м зайтай, тавиур хоорондын зай 0.75 м байна.

Дөрөв. Эм, урвалж бодисын хадгалалт, тээвэрлэлт

- 4.1 Эм, урвалж бодис, эмнэлгийн хэрэгслийг цувралын дагуу бүртгэж, үйлдвэрлэгчийн сав баглаа боодлоор нь хадгалж, орлого, зарлагыг тооцно.
- 4.2 Овор, жин ихтэй эм, урвалж бодисыг суурь тавиур дээр, хайрцаг дээрх сумаар тэмдэглэсэн заалтын дагуу дээш нь харуулан хүчинтэй хугацааг харагдахуйцаар байрлуулж, боломжгүй бол эм, урвалж бодисын нэр, хүчинтэй хугацааг харагдахуйц газар тэмдэглэнэ.
- 4.3 Шингэн эм, урвалж бодисыг тавиур, шүүгээний доод хэсэгт, гэрэлд мэдрэг эмийг харанхуй орчинд, шатамхай бодисыг агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусдаггүй, сэрүүн газар горимын дагуу хадгална. Эм, урвалж бодисыг физик, химийн шинж чанартай нь уялдуулан үйлдвэрлэгчийн заасан хэм, чийглэг, гэрэлтүүлгийг хангасан нөхцөлд хадгална.
- 4.4 Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг зохих журмын дагуу тусгайлан битүүмжилж, зориулалтын шүүгээнд хадгална.
- 4.5 Хүчинтэй хугацаа дууссан, физик чанар байдал өөрчлөгдсөн эм, урвалж бодисыг тусгайлан хадгалж, ажлын хэсэг зааврын дагуу баримтжуулан устгана.
- 4.6 Сүрьеэгийн эм, эмэнд дасалтай сүрьеэгийн гаж нөлөөний эмийг гэмтээж үрэгдүүлэхгүй, чийгнээс хамгаалж тээвэрлэнэ.
- 4.7 Эмийг гэмтээж, үрэгдүүлсэн тохиолдолд буруутай ажилтан хариуцлага хүлээнэ.

Тав. Эм, урвалж бодис хуваарилах

Сүрьеэгийн нэгж байгууллагуудын тухайн жилийн нийт өвчлөл, хийгдсэн шинжилгээний тоонд үндэслэн эм, урвалж бодисыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилна.

Зургаа. Эм, урвалж бодис олголт, зарцуулалт, хяналт

- 6.1 Сүрьеэгийн нэгж байгууллагад эм, урвалж бодисыг батлагдсан хуваарийн дагуу улирлын нөөцтэй олгоно.
- 6.2 Сүрьеэгийн клиникийн эм хариуцсан мэргэжилтэн эмчлэгч эмчийн бичсэн эмийн жорыг үндэслэн эмийг цомгоор олгоно.
- 6.3 Эмэнд дасалтай сүрьеэгийн гаж нөлөөний эмийг жорын дагуу баталгаажуулж олгоно.
- 6.4 Өвчтөн шилжих, нас барах, онош өөрчлөгдөх тохиолдолд үлдэгдэл эмийг тухайн газрын нөөцөнд оруулж мэдээлнэ.
- 6.5 Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт эмчлүүлэх хугацаанд сүрьеэтэй нь батлагдсан тохиолдолд зөвлөгөө өгсөн эмчийн жорыг үндэслэн эмч нарын зөвлөгөөнөөр эмийг олгож, эмчилгээний үр дүнг эргэн тооцно.
- 6.6 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч, эмийн сувилагч нь ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт, судалгааны албаны эм олгох журмын дагуу эмийн цомгийг авч, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, өрх, сумын эмч, хоолтой эмчилгээний болон өдрийн эмчилгээний цэгт олгож, хэрэглээнд хяналт тавина.
- 6.7 Сүрьеэгийн эм, эмэнд дасалтай сүрьеэгийн гаж нөлөөний эмийг зөвхөн сүрьеэтэй өвчтөнд үнэ төлбөргүй хэрэглэнэ.
- 6.8 Нэгжүүдийн эм, урвалж бодисын хэрэглээ, хадгалалт, зарцуулалтад тухайн нэгжийн зохицуулагч эмч, клиникийн тасгийн эрхлэгч хяналт тавина.
- 6.9 СТСА-ны хяналтын эмч нар аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, сүрьеэгийн клиник болон бусад эмнэлэгт хуваарийн дагуу эмчилгээний хяналт, эмийн хадгалалт, хамгаалалт, хэрэглээнд долоодугаар хавсралтын дагуу хяналт хийнэ.
- 6.10 Сүрьеэгийн эм, урвалж бодисыг зарж борлуулсан, зориулалтын бусаар хэрэглэсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сүрьеэгийн тархвар судлал, халдвар хяналтын удирдамж

Сүрьеэгийн халдварын гинжин хэлхээ нь өвчин үүсгэгч, халдварын эх уурхай, халдвар дамжих зам, өрөмхий бие махбодь гэсэн зүйлүүдээс хамаарна.

Нэг. Үүсгэгч

Сүрьеэгийн үүсгэгч нь *Mycobacterium tuberculosis complex* (*M. tuberculosis*, *M. bovis*, *M. africanum*, *M. Microti*) бөгөөд янз бүрийн нөхцөлд дасан зохицох чадвартай, олон эрхтэнийг гэмтээдэг онцлогтой.

Сүрьеэгийн үүсгэгч нь гадаад орчинд маш тэсвэртэй, тоосонд 100 ба түүнээс дээш хоног, номын хуудсанд 3 сар, хөрсөнд 6 сар, усанд 150 хоног, булшлагдсан цогцсонд хэдэн сарын турш хадгалагдана. Хатсан цэрэнд 10-12 сарын турш амьд байдаг. Сүүн бүтээгдэхүүнд маш удаан ялангуяа цөцгийн тосонд хүйтэн нөхцөлд 1 жил, бяслагт 260 хоног хадгалагдана.

-40oC хэмд 50 жил амьдрах чадвараа хадгалах ба бусад нянтай харьцуулахад удаан 20-24 цагт нэг удаа хуваагдаж үржинэ.

Сүрьеэгийн үүсгэгчийн эсийн хана царцамхай өөх, тос ихээр агуулдаг тул физик-химийн хүчин зүйлс, хүчил, шүлтэнд тэсвэртэй байдаг. Ходоодны хүчилд 6 цаг тэсвэрлэх чадвартай.

Буцалгахад 10 минут, чийгтэй нөхцөлд 75oC хэмд 30 минут, нарны шууд гэрэл болон хэт ягаан туяанд 1 цагийн дотор устана.

Хоёр. Халдварын эх уурхай

Нян ялгаруулж байгаа уушгины халдвартай сүрьеэтэй өвчтөн халдварын эх уурхай болно. Халдвартай хэлбэрийн уушгины сүрьеэтэй нэг өвчтөн эмчлүүлээгүй тохиолдолд жилд 15-20 хүнд халдвар тараана.

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтлыг халдвар авах эгзэгээр 4 хүрээ болгоно.

1. Өвчтөнтэй хамт амьдардаг хүмүүс

-
2. Ойрын хамаатан, найз нөхөд
 3. Хамт ажиллагсад
 4. Бусад

Халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн хүний гэр бүлийн гишүүд халдвар авах магадлал өндөр, хүрээ гадагшлах тусам халдвар авах эгзэг нь буурна.

Сүрьеэгийн нян амьсгалын замаар дамжин хүний биед орж халдварлуулдаг боловч дархлалын тогтолцоо нянгийн өсөлтийг зогсоож идэвхигүй болгохыг сүрьеэгийн нянгаар халдварлагдсан гэнэ.

Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан хүн:

- Эмнэл зүйн шинж тэмдэггүй
- Туберкулины сорил эерэг, бусад шинжилгээнд өөрчлөлтгүй
- Бусдад халдвар тараахгүй

Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан тохиолдлын 10% нь дархлаа бууруулах хүчин зүйл нөлөөлснөөс сүрьеэгээр өвчилдөг.

Гурав. Халдвар дамжих зам

Сүрьеэ нь голдуу агаар дуслын замаар дамжин тархдаг. Сүрьеэтэй өвчтөн ярих, найтаах, дуулах ялангуяа ханиалгахад сүрьеэгийн нян агуулсан жижиг дуслыг агаарт цацдаг.

Сүрьеэтэй өвчтөн бусдад халдвар тараахад нөлөөлөх хүчин зүйлс:

- Ойрхон давтамжтай олон удаа ханиалгах
- Их хэмжээтэй, наалдамхай цэр ялгаруулах
- Хожуу оношлогдох, эмчилгээ таслах
- Агааржуулалт муутай орчин

Дөрөв. Өртөмхий бие махбодь

Хүний бие махбодь сүрьеэгийн халдварыг эсэргүүцэх байгалийн өндөр чадвартай, энэ нь хүний амьдралын туршид харилцан адилгүй байдаг.

4.1 Насны онцлог

- Бага насанд сүрьеэгийн нянгаар халдвар авбал тархмал, даамжирсан хүнд хэлбэр элбэг тохиолдох магадлалтай.
- 7-13 насанд өвчлөл ховор, өвчилсөн тохиолдолд эмчилгээ

ихэнхдээ үр дүнтэй.

- 14-16 насанд халдвар идэвхжин насны онцлогоос хамааран хүнд хэлбэр тохиолдож болдог.
- Идэр, залуу насанд анхдагч, хоёрдогч халдвар идэвхжих нь хамгийн элбэг тохиолддог.
- Ахимаг, өндөр настанд ихэвчлэн архаг, соривт-хөндийт, эмнэлзүйн шинж тэмдэггүй хэлбэр цөөнгүй тохиолдоно.

4.2 Сүрьеэгийн халдварт өртөх эрсдэл өндөртэй бүлэг

- Сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал
- ХДХВ-ийн халдвартай хүмүүс
- Архи, мансууруулах бодист донтогсод
- Эрүүл мэндтэй холбоотой эрсдэлт бүлгийн хүмүүс
- Хүн ам олноор бөөгнөрсөн эрсдэл өндөртэй орчинд ажиллаж, амьдрагсад (хүүхэд, өндөр настаны асрамжийн газар, сэтгэцийн эмнэлэг, хорих анги, түр саатуулах байр, орон гэргүй хүмүүсийн түр орогнох байр)
- Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн ажилчид, сайн дурын идэвхтэн
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэж чадахгүй, орлого багатай, тодорхой оршин суух хаяггүй, орон гэргүй иргэд
- Эрсдэл өндөртэй насанд хүрэгчидтэй хамт амьдарч буй нярай, бага нас, өсвөр үеийн хүүхдүүд

4.3 Эрүүл мэндтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлс

- ХДХВ-ийн халдвар
- Чихрийн шижин
- Кортикостероид болон дархлаа дарангуйлах эмчилгээ удаан хугацаагаар хийлгэх, (ясны чөмөг болон эрхтэн шилжүүлэн суулгасан)
- Бөөрний архаг дутагдал
- Зарим цусны эмгэг (лейкеми, лимфома)
- Бусад өвөрмөц хавдар (хүзүү, толгойн карцинома)
- Хэт туранхай (биеийн жингийн 10%-тай тэнцэх)
- Уушги тоосжих өвчин
- Ходоод тайруулсан
- Өлөн, цутгалан гэдэсний залгаас хийлгэсэн

Тав. Сүрьеэгийн голомт

Сүрьеэгийн халдварын эх уурхай, өртөмхий бие махбодь, дамжих замыг нэгтгэн сүрьеэгийн голомт гэнэ.

Сүрьеэгийн голомтын хүрээг өвчлөл бүртгэгдсэн сум, өрх, аймаг, дүүргийн мэргэжилтэн тогтооно. Нийтийн орон сууц, дотуур байр, халамж, асрамжийн төв, сүм, хорих анги, эрүүл мэндийн байгууллагын голомтод онцгой анхаарна.

Голомтонд халдвар авах эрсдэл:

- Өвчтөний нян ялгаруулж байгаа хугацаа
- Хавьтагсдын халдварт өртөх хугацаанаас хамаарна.

Сүрьеэгийн голомтыг 3 бүлэг болгоно:

- Сүрьеэгийн халдвар тархах хамгийн өндөр эрсдэлтэй
- Сүрьеэгийн халдвар тархах бага эрсдэлтэй
- Сүрьеэгийн халдвар тархах магадлалтай

Зургаа. Сүрьеэгийн хавьтлын судалгаа

Хавьтлын судалгааны зорилго нь сүрьеэгийн эх уурхайг тогтооход оршино. Судалгааг хийхийн өмнө тохиолдлын индекс (өвчтөн), хавьтлын тодорхойлолтыг гаргана.

6.1 Тохиолдлын индекс:

- Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй
- Сүрьеэгээр өвчилсөн хүүхэд
- Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг хэлнэ.

6.2 Хавьтал

Өвчтөн оношлогдох үед хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийг хавьтал гэнэ. Хэрэв хүн олноор бөөгнөрсөн орчинд удаан хугацаагаар хавьтал болсон бол хавьтлын тодорхойлолтыг өргөжүүлэн авч үзнэ.

6.3 Хавьтлын судалгаа

6.3.1 Тохиолдлын индекс (өвчтөн)-ийг оношлогдсоны дараа нэн тэргүүнд хамт амьдарч байгаа гэр бүлийн хавьтлыг тодруулна.

6.3.2 Хавьтлын судалгааг гаргаж сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж ялангуяа 0-16 насны хүүхэд, ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг онцгой анхаарна.

6.4 Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтлын хяналт

- 6.4.1 Тохиолдлын индексийг оношлогдсоноос хойш 14 хоногийн дотор хавьтлыг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулна. Хавьтлын үзлэгийг харьяа сум, өрхийн эмнэлэг, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, Эрүүл мэндийн нэгдэлд үнэ төлбөргүй хийнэ.
- 6.4.2 Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн, сүрьеэгээр өвчилсөн хүүхдийн хавьтлыг жилд нэг удаа, 5 жилийн турш сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж хяналт хийнэ.
- 6.4.3 Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний хавьтлыг эхний 2 жилд 6 сар тутам, хойшид жилд нэг удаа сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж нийт 5 жил хянаж зөвлөгөө өгнө.
- 6.4.4 Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал 0-16 насны хүүхдүүдэд туберкулины сорил тавина.
- 6.4.5 Туберкулины сорилын урвал 10 мм-ээс дээш хэмжээтэй гарсан 5-аас дээш насны хүүхдэд холбогдох бусад шинжилгээ хийж, идэвхитэй хэлбэрийн сүрьеэгүй бол харьяа сум, өрхийн эмчийн хяналтанд байлгана.
- 6.4.6 Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу БЦЖ вакцинд хамрагдаагүй, БЦЖ вакцины сорвигүй хүүхдэд туберкулины сорил тавьж сөрөг урвалтай тохиолдолд 3-4 долоо хоногийн дараа сорил давтан тавьж урвалыг сөрөг гэдгийг баталгаажуулсан тохиолдолд нөхөн дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4.7 Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, цэцэрлэгийн хүүхэд сүрьеэгийн ямар нэгэн хэлбэрээр өвчилсөн эсвэл эдгээр байгууллагын ажиллагсад уушгины түрхэц эерэг сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд тухайн сургууль, цэцэрлэгийн багш, ажиллагсад, ангийн бүх хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

6.5 Хавьтлын урьдчилан сэргийлэх эмчилгээ

- 6.5.1 Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 хүртэлх насны хүүхдэд сорилын урвал 10 мм-ээс дээш хэмжээтэй гарч эмнэлзүй, бусад шинжилгээгээр сүрьеэ үгүйсгэгдсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх эмчилгээг изониазидаар, өдөрт 10 мг/кг-аар /хоногийн дээд тун 300 мг/ харьяа сум,

өрхийн эмнэлэг, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч хяналтанд 6 сар хийнэ.

- 6.5.2 Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал, сүрьеэтэй нь батлагдаагүй ХДХВ-ийн халдвартай хүнийг урьдчилан сэргийлэх изониазид эмчилгээнд хамруулна. Өдөрт 300 мг-аар 6-9 сар эмчилнэ.

6.6 Хавьтлаас шинж тэмдэг илэрч өвчилсөн тохиолдол

- 6.6.1 Сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэг илэрвэл холбогдох шинжилгээг хийж, өвчилсөн тохиолдолд бүртгэж, горимын дагуу эмчилгээнд хамруулна.
- 6.6.2 Сүрьеэгийн сэжигтэй хавьтал үзлэг, шинжилгээгээр сүрьеэ батлагдаагүй тохиолдолд өргөн хүрээний антибиотик эмчилгээ хийнэ.
- 6.6.3 Өргөн хүрээний антибиотик эмчилгээний төгсгөлд шинж тэмдэг хэвээр байвал нарийвчилсан шинжилгээ, цэрний түрхэц, өсгөвөрлөх шинжилгээ давтан хийж оношийг тодруулна.

6.7 Эмэнд дасалтай сүрьеэгийн хавьтлаас өвчилсөн тохиолдол

- 6.7.1 Эмэнд мэдрэг сүрьеэгийн эмчилгээ эхлэнэ.
- 6.7.2 Өсгөвөрлөх шинжилгээ хийж эмэнд мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээ хийнэ.
- 6.7.3 ХДХВ-ийн зөвлөгөө, шинжилгээнд хамруулна.

Долоо. Эмнэлгээс шалтгаалсан сүрьеэгийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

Халдвар хяналт гэдэг нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад эмнэлгээс шалтгаалсан халдвар үүсэх, тархахаас сэргийлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын болон халдвараас сэргийлэх арга хэмжээний иж бүрдэл тогтолцоо юм.

Энэхүү тогтолцооны зорилго нь эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оршино.

7.1 Тодорхойлолт

Эмнэлгийн дотор сүрьеэ тархах гэдэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний явцад халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс *Mycobacterium tuberculosis* бусад өвчтөн, эмч, эмнэлгийн ажилтанд халдварлахыг хэлнэ.

Эмнэлгээс шалтгаалсан сүрьеэгийн халдвараас сэргийлэх арга хэмжээний 3 түвшин байна.

1. Удирдлага, зохион байгуулалт
2. Орчны сэргийлэлтийн арга хэмжээ
3. Хувийн хамгаалах хэрэгсэл

7.2 Удирдлага, зохион байгуулалт

- 7.2.1 Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага нь сүрьеэгийн халдвар тархах эгзгийг үнэлэн эрсдэл өндөртэй тасаг, нэгжийг тодруулж түүнд чиглэсэн арга хэмжээ авна.
- 7.2.2 Халдвар хяналтын төлөвлөгөө боловсруулж ажиллана.
- 7.2.3 Эмч, эмнэлгийн ажилтнуудыг сүрьеэ, түүний тархах зам, халдварын хяналт, сэргийлэх арга хэмжээний талаар сургалтад хамруулсан байна.
- 7.2.4 Ханиах, найтаах үедээ амаа таглаж байхын чухлыг өвчтөнд зааж сургана.
- 7.2.5 Цэрийг агааржилт сайтай газар авна.
- 7.2.6 Сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэг илэрсэн өвчтөнийг амбулаторт эхэлж үзнэ.
- 7.2.7 Лабораторийн био аюулгүй ажиллагааны удирдамжийг мөрдөж ажиллана.

7.3 Орчны хяналтын арга хэмжээ

- 7.3.1 Байгалийн болон механик агааржуулалттай байна. Өрөө тасалгааны цонхыг онгойлгож агааржуулна.
- 7.3.2 Механик агааржуулалтын системийн хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавина.
- 7.3.3 Өрөөний агаарыг 200-280 нм долгионы урттай хэт ягаан туяа цацруулах гэрэл ашиглаж ариутгана. Кварцын гэрлийг таазны ойр, өрөөний дээд хэсэгт өвчтөн, эмч, эмнэлгийн ажилтан өртөхгүйгээр байрлуулна. Өрөөний агаарын солилцоог сайн байлгах хэрэгтэй. Бактерицид гэрлийн ашигласан цагийг тооцон тэмдэглэж, зааварт заасан ашиглах хугацаа дууссан тохиолдолд солино.

7.3.4 Зөөврийн болон суурин дезарийг ашиглан хэт ягаан туяагаар ерөөний агаарыг халдваргүйтгэнэ.

7.4 Хувийн хамгаалах хэрэгсэл

7.4.1 Шүүгчтэй маск буюу респиратор N95, N100, 3M:

Шүүгчтэй маск N95, N100 нь 0.3µм-ээс дээш хэмжээтэй агаарын дуслыг 95-100% шүүдэг. Доорхи тохиолдолд N95, N100, 3M-ын аль нэгийг заавал зүүнэ.

- Уушгины түрхэц эерэг сүрьеэ, эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг тусгаарлах, эмчлэх тасаг, эмнэлэг, амбулатори, өдрийн эмчилгээний цэгт ажиллах
- Сүрьеэгийн лабораторид түрхэц бэлдэх, өсгөвөр тарих
- Цэрний сорьц цуглуулах
- Бронхоскопи хийх
- Задлан шинжилгээ хийх
- Уушгины багтаамж хэмжих
- Сүрьеэгийн халдвартай байж болох өвчтөнд яаралтай мэс засал хийх

7.4.2 Амны хаалт:

Эмчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа халдвартай хэлбэрийн сүрьеэтэй бүх өвчтөн амны хаалт заавал зүүнэ.

7.4.3 Шүүгчтэй маск хадгалах:

Шүүгчтэй маскийг (N95, N100, 3M) хуурай, цэвэр, зөв хадгалсан тохиолдолд 1 сар хүртэл хэрэглэж болно.

- Маскийг гэмтээх гол хүчин зүйлүүд нь чийг, тоос шороо, хир, дарагдах тул дарж, гэмтээхгүй цайвар алчуураар эргэн тойрон бүтээж хадгална.
- Чийг татдаг учир хуванцар, нийлэг гялгар уутанд маскийг хадгалж болохгүй, үйлдвэрийн өөрийн саванд хийж тээвэрлэхдээ дарж хэлбэрийг нь алдуулах, гэмтээх, норгохоос болгоомжилно.

7.4.4 Шүүгчтэй маскны таарч буйг шалгах сорил

Шүүгчтэй маск нь өөр өөр хэмжээтэй байдаг учраас эрүүл мэндийн ажилчид тохироо шалгах чанарын сорилд хамрагдаж, өөртөө таарсан маскийг зөв сонгож битүүмжлэлийг шалган хэрэглэнэ.

- Эерэг даралт үүсгэн шалгах: Маскийг зүүж амьсгалаа хацрын хэсэг руу аажим гаргана. Хацарт таарч байгаа бол

маск хэлбэрээ хадгалж, гадагш агаар гарч байгаа ямар нэг нотолгоо байхгүй байна.

- Сөрөг даралт үүсгэн шалгах: Маскийг зүүгээд амьсгал аажим авахад хацрын хэсгээр ялимгүй татагдана. Амьсгалаа 10 секунд барихад хацрын хэсэгт ялимгүй татагдсан байдал хэвээр хадгалагдаж, агаар дотогш орж буй нотолгоо байхгүй бол маскийг чангалаад таарсан гэж үзнэ.

7.4.5 Шүүгчтэй маск N95, N100, 3М-ийг өмсөх, тайлах дараалал
Шүүгчтэй маск N95, N100, 3М-ийг дагалдан ирдэг өмсөх, тайлах зааврын дагуу хэрэглэнэ.

Хэрэглэх хугацаа дууссан, хир, тос, тоос болсон, урагдсан, норсон тохиолдолд маскийг шатааж устгана.

7.5 Халдваргүйтгэл

Сүрьеэгийн нян гадаад орчинд болон ихэнх халдваргүйтгэлийн уусмалд тэсвэртэй тул ариутгал, халдваргүйтгэлийг дараах аргуудыг сонгон хэрэглэнэ.

7.5.1 Цэр халдваргүйтгэх, устгах

Лабораторид дараах халдваргүйтгэх уусмалын аль нэгээс өвчтөний цэртэй ижил хэмжээтэй хийж цэрийг халдваргүйтгэнэ.

- 5%-ийн фенолын уусмалд 18-24 цаг
- 2%-ийн лизолын уусмалд 12 цаг
- 3%-ийн вирконы уусмалд 15 минут
- 1-2%-ийн натрийн буюу калийн гипохлоридын уусмалд 12 цагаас дээш хугацаагаар байлгахад халдваргүй болно.

Сүрьеэгийн тасаг, нэгжүүдэд өвчтөний цэр устгах

- Халдваргүйтгэлийн уусмалтай цэр цуглуулах савыг өвчтөнд өдөрт 3 удаа тухайн тасаг нэгжээс олгож устгалд хяналт тавина. Өвчтөн бүрийг ялгах таних тэмдэг бүхий цэрний савыг олгоно.
- Цэрний халдваргүйтгэлд дээрх бодисуудаас аль нэгийг сонгож хэрэглэнэ.
- Эмнэлгээс гарах хүртэл цэрний устгалыг тогтмол хянана.

7.5.2 Эмнэлгийн багаж хэрэгсэлийн халдваргүйтгэл:

Эд, хэрэгсэл	Бодисын нэр, үйлдвэрлэсэн компани, улс	Ажлын уусмалын концентрац (%)	Ажлын уусмалын хэм (С°)	Халдваргүй-жүүлэх хугацаа (мин)
Мэс засал, шүд, эрүү, нүүрний багаж (шил, резин, хуванцар, металл)	Аламинол ("НИОПЕК" Орос)	3.0	18 хэмээс багагүй	90
	ИД 212 (Герман)	4.0	18 хэмээс багагүй	60
Дуран (шил, резин, хуванцар, металл)	Бианол (Орос)	1.5	18 хэмээс багагүй	30
	Стераниос 20% ("Аниос" Франц)	1.0	18 хэмээс багагүй	15
	Септодор-форте ("Дорвет " Израиль)	0.4	18 хэмээс багагүй	90
	Дезэффект (АНУ)	3:128	18 хэмээс багагүй	60
	Корзолин ИД (Герман)	3.0	18 хэмээс Багагүй	60
	Дезоформ (Герман)	1.0	18 хэмээс багагүй	90
	Секусепт-форте (Финлянд)	5.0	18 хэмээс багагүй	30
	Хелипур Х плюс (Герман)	2.5	18 хэмээс багагүй	90
	Дюльбак уусмал (Франц)	- ¹	18 хэмээс багагүй	90
Дуран, эрүү, нүүрний мэс заслын багаж (шил, резин, хуванцар, металл)	Глутарал (Орос)	-	18 хэмээс багагүй	90
	Глутарал-Н (Орос)	-	18 хэмээс багагүй	90
	Сайдекс (АНУ)	-	18 хэмээс багагүй	90
	Гигасепт	3.0	18 хэмээс багагүй	60
	Лизоформин 3000 (Герман)	0.75	18 хэмээс багагүй	60
	КолдСпор	10.0	18 хэмээс багагүй	10
	Велтосепт (Орос)	-	18 хэмээс багагүй	30
	Велтолен (Орос)	5.0	18 хэмээс багагүй	60

Шил, металл, хуванцар, резинэн эдлэл	Формалин (формальдегид)	10.0	18 хэмээс багагүй	60
	Альдазан 2000 (Герман)	3.0	18 хэмээс багагүй	60
	Деконекс 50 ФФ	1.5	18 хэмээс багагүй	120
	Альдесол (Хорват)	3.0	18 хэмээс багагүй	60
	Лизетол АФ	2.0	18 хэмээс багагүй	60
	Плиасепт 5% глюконат (Хорват)	0.5 Ус спиртэн уусмал	18 хэмээс багагүй	30
Шил, зэвэрдэг металл, хуванцар, резинэн материал	Устөрөгчийн хэт исэл (Орос)	3.0	18 хэмээс багагүй	180
	Пероксимед (Орос)	3.0	18 хэмээс багагүй	120
	Дезоксон-1 Дезоксон-4 (Орос)	0.5	18 хэмээс багагүй	60
Шил, зэвэрдэг металл, полимер материал	Жавелион (Франц)	0.2	18 хэмээс Багагүй	60
	Пюржавель (Франц)	0.2	18 хэмээс багагүй	60
	Деохлор (Франц)	0.2	18 хэмээс багагүй	60
	Персепт (АНУ)	0.28	18 хэмээс багагүй	45
	Хлорамин (Орос)	5.0	18 хэмээс багагүй	240
Шил, хуванцар, силикон, резин	Анолит	0.02-0.06	18 хэмээс багагүй	30-300
Эрүү, нүүрний багаж	Гротанат борербад (Герман)	-	18 хэмээс багагүй	30
	ИД 220 (Герман)	-	18 хэмээс багагүй	30

7.5 Бусад

- Автоклавыг ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар хэрэглэнэ. Бохирлогдсон цэрний савыг 121оС-ийн хэмд 1 цаг, харин угааж цэвэрлэсэн савыг 30 минутын турш ариутгана.
- Эмэнд дасалтай сүрьеэгийн тасаг болон сүрьеэгийн лабораторид нян устгах үйлчилгээтэй хэт ягаан туяаны гэрлийг 15 минутаас дээш хугацаагаар асаана.
- Ариутгах боломжгүй нэг удаагийн хэрэглээний материалуудыг шатааж устгана.

-
- Өвчтөний эдлэл (хөнжил, гудас, дэр, бүтээлэг гэх мэт) хэрэглэлийг дезкамерт халдваргүйжүүлэх эсвэл нарны шууд туяанд 8 цагаас доошгүй хугацаагаар тавина.

7.6. Эмэнд дасалтай сүрьеэгийн халдвар хяналтын дэглэм

- 7.6.1 Сүрьеэгийн нэгж байгууллагуудад “Халдварын хяналтын тогтолцоог бэхжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2008 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 85 тоот тушаал, “Журам шинэчлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2003 оны 313 тоот тушаал, “Хог хаягдлын менежментийг сайжруулах тухай” Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2002 оны 249/201 тоот тушаал болон энэхүү тушаалын заалтуудыг мөрдөж ажиллана.
- 7.6.2 Эрүүл мэндийн байгууллагын Халдварын хяналтын баг, хороо нь эмэнд дасалтай сүрьеэгийн эмнэлгээс шалтгаалсан халдвар байдлаар тархахаас сэргийлж хяналт тавьж ажиллана.
- 7.6.3 Сүрьеэгийн нэгж байгууллагуудад зориулалтын агааржуулалтын систем, өрөөний агаарыг сэлгэх салхивч, нян устгах үйлчилгээтэй хэт ягаан туяаны гэрэл (11V “С” 200-280 нт)-ээр хангагдсан байна.
- 7.6.4 Цэрний түрхэц бэлтгэх, өсгөвөрлөх, эмийн мэдрэг чанар тодорхойлох лабораторид био аюулгүй ажиллагааны II ангиллын сорох шүүгээ ашиглана.

7.7 Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнг эмчлэх, сувилах үед баримтлах дэглэм

- 7.7.1 Цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг байгаа эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг сүрьеэгийн эмчийн хяналтанд халдвар хяналтын дэглэмийг баримтлан эмчилнэ.
- 7.7.2 Цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхдээ шүүлтүүртэй маск (N95, N100, 3M) заавал хэрэглэнэ.
- 7.7.3 Эмэнд дасалтай сүрьеэтэй байж болзошгүй өвчтөний сорьцонд шинжилгээ хийх эмч, лаборант нар шүүлтүүртэй маск (N95, N100, 3M) заавал хэрэглэнэ.
- 7.7.4 Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнд цэрний өсгөвөрлөх шинжилгээний хариу 2 сар дараалан сөрөг болтол амны

хаалт хэрэглүүлж, цэрийг зориулалтын саванд цуглуулж, өдөр бүр халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйтгэнэ.

7.8 Эмэнд дасалтай сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэгт баримтлах дэглэм

- 7.8.1 Өдрийн эмчилгээний цэгээр эмчлүүлж байгаа өвчтөнийг халдвартай, халдваргүйгээр нь тус тусдаа өрөөтэй байх, эсвэл цагийн хуваарь гарган эмчилгээг явуулна.
- 7.8.2 Эмч, эмнэлгийн ажилчдыг сургалтанд хамруулсан байна.
- 7.8.3 Өвчтөнг бүрэн төгс эмчилнэ.
- 7.8.4 Халдвар хамгааллын дэглэм дээрхитэй ижил байна.

7.9 Радиологийн тасагт баримтлах халдвар хяналтын дэглэм

Тус тасагт сүрьеэгийн халдварт өртөх эрсдэл өндөртэй хүмүүс үйлчлүүлдэг учир халдвар хяналтын дэглэмийг баримтлана.

- 7.2.1 Эмнэлэгт хэвтэж байгаа сүрьеэгийн халдвартай болон сэжигтэй өвчтөний цээжний зургийг авах цагийн хуваарь гаргаж үйлчилнэ.
- 7.2.2 Ханиалгаж байгаа өвчтөнд амны хаалт заавал зүүлгэнэ.
- 7.2.3 Амбулаториор сүрьеэгийн сэжигтэй өвчтөнд дугаар харгалзахгүй үйлчилнэ.
- 7.2.4 Сүрьеэгийн сэжигтэй өвчтөний зургийг агааржуулалт сайтай өрөөнд авна.

7.3 Сүрьеэтэй жирэмсэн эхийн амаржих газарт тавигдах шаардлага

- 7.3.1 Сүрьеэтэй эхийн төрөх тасаг нь төрөхийн өмнөх өрөө, төрөх өрөө, төрсний дараах эх, нярайн өрөө (палат), төрөхийн өмнө ба төрсний дараах үзлэгийн өрөө, төрсөн эхийн угаалгын өрөө, нярайн өрөө, ариутгалын болон бусад туслах өрөөнүүдээс бүрдэнэ.
- 7.3.2 Цэрний түрхэц, өсгөвөр эерэг болон эмэнд дасалтай сүрьеэтэй эхэд амны хаалт, төрөх тасагт ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнууд шүүгчтэй маск зүүнэ. Цэрний түрхэц, өсгөвөр эерэг болон эмэнд дасалтай сүрьеэтэй эх хүүхдээ хөхүүлэх, асрах үед шүүгчтэй маскийг тогтмол зүүнэ. Өрөөний агааржуулалтыг тогтмол хийнэ.
- 7.3.3 Төрөх тасагт жирэмсэн болон эх, нярайд тусламж, үйлчилгээ

үзүүлэхдээ “Халдвараас сэргийлэх арга хэмжээний удирдамж”-ийг мөрдлөг болгож ажиллана.

7.4 Сүрьеэгийн лабораторийн био аюулгүй ажиллагааны заавар

7.4.1 Лабораторийн аюулгүй байдал

Лабораторийн аюулгүй ажиллагааны талаар дараах тушаал, зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын “Халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх тухай” 2008 оны 85 тоот тушаал
- Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын “Журам батлах тухай” 2006 оны 70 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын “Жагсаалт, журам батлах тухай” 2006 оны 403 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах тухай” 2002 оны 249/201 тоот тушаал
- ДЭМБ-ын Лабораторийн аюулгүй ажиллагааны гарын авлага, 3 дахь хэвлэл

7.5 Эрүүл мэндийн ажилтнуудын дунд сүрьеэгийн халдвар, өвчлөлийн тандалт хийх

7.5.1 Сүрьеэгийн нэгж байгууллагад анх ажилд орж буй эмч, сувилагч, лаборант, асрагч, шил угаагч, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, бусад ажилтаныг сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, туберкулины сорил тавьж, эрүүл мэндийн хяналтын тусгай дэвтэр хөтлөн, жилд 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна.

7.5.2 Бүх ажилтнуудыг сүрьеэгийн эмнэлзүй, халдвар хяналтын талаар сургалтанд хамруулсан байна.

7.5.3 Эрүүл мэндийн байгууллагын ажилчдаас сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд тархвар судалгаа хийж СТСА-д мэдээлнэ.

7.5.4 Судалгаанд ажлын байр, мэргэжил, халдварын эх уурхай, эмчилгээний байдал, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний хариу зэрэг мэдээллийг бүрэн хамруулна.

Найм. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

8.1 Сүрьеэгийн эсрэг дархлаажуулалт

БЦЖ вакцин нь хүүхдийг тархмал хэлбэрийн сүрьеэ, сүрьеэгийн менингитээс найдвартай хамгаална.

8.1.1 Нярайг төрсний дараа 24 цагийн дотор эсрэг заалт байгаа эсэхийг тодруулсны дараа бэлтгэгдсэн сувилагч БЦЖ вакцинаар дархлаажуулан тарилгын болон эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ. Вакцин хийгдээгүй бол шалтгааныг заана. Вакцины дараах хүндрэл гарсан тохиолдолд холбогдох зааврын дагуу мэдээлж арга хэмжээ авна.

8.1.2 БЦЖ вакцины эсрэг заалт

- Дутуу төрсөн II-IV зэрэг
- Ургийн тураал III-IV зэрэг
- Ургийн халдвар
- Идээт-үжил өвчин
- Нярайн цус задрах өвчин (дунд-хүнд, хүнд хэлбэр)
- Түгээмэл хэлбэрийн арьсны гэмтэл
- Хурц өвчин
- Гэр бүлийн сүрьеэгийн хавьтлын анамнез
- Төрөх үеийн тархи нугасны гэмтэл, гаж хөгжил

8.1.3 Нөхөн дархлаажуулалт

- Нярайд хийсэн БЦЖ вакцины анхны тунгийн үр дүнг 1, 3, 12 сартайд нь вакцины урвалын байдал (гүвдрүү, шархлаа, сорви), хэмжээгээр нь үнэлэн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хэрэв сорви үүсээгүй бол туберкулины сорил тавьж сөрөг тохиолдолд нөхөн дархлаажуулна.
- Төрөхөд хориглох заалтаар БЦЖ вакцин хийлгээгүй хүүхдэд хориглох заалт арилсны дараа туберкулины сорил тавьж нөхөн дархлаажуулалт хийнэ.

8.2 Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх бусад арга хэмжээ

8.2.1 Нийт хүн амын дунд сүрьеэ өвчний тухай үнэн зөв ойлголтыг хүргэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэй хэлбэрээр мэдээлэл сурталчилгааны бүх хэрэгслийг ашиглан тогтмол явуулах ажлыг бүх шатны эрүүл мэндийн байгууллага тогтмол зохион байгуулна.

8.2.2 Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй шинэ тохиолдлыг эрт илрүүлж бүрэн төгс эмчилнэ.

-
- 8.2.3 Сүрьеэгийн хавьталгүй туберкулины сорил хэт өндөр эерэг гарсан (17мм-ээс дээш) 0-16 насны хүүхдийг сүрьеэ өвчнийг оношлох шинжилгээнд хамруулж, шаардлагатай тохиолдолд 5 хүртэлх насанд урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.
- 8.2.4 Орон гэргүй, тодорхой хаяггүй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой жирэмсэн эхчүүдэд сүрьеэгийн үзлэг хийнэ.
- 8.2.5 Архаг хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний гэр бүлийн гишүүдийг жил бүр сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны
сарын...өдрийнтоот тушаалын
долоодугаар хавсралт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж

Нэг. Дэмжлэгт хяналт

Дэмжлэгт хяналт нь эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ур чадвар, ажилдаа хандах хандлага харьцааг сайжруулж, тэдний ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд дэс дараатай, тасралтгүй явуулж буй үйл ажиллагаа юм. Сүрьеэгийн нэгж байгууллагын үйл ажиллагаа, анхан шатны маягтын хөтлөлт, бичиг баримттай газар дээр нь танилцаж, эрүүл мэндийн ажилтан болон өвчтөнтэй уулзах замаар дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгнө.

Хоёр. Хяналт-шинжилгээ

Хяналт-шинжилгээ нь стратегийн төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих үйл явц юм.

Зорилго нь тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээг хийхдээ хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нэгжид очих эсвэл тогтмол гаргадаг тайлан мэдээнд дүгнэлт хийх замаар явуулна.

Гурав. Үнэлгээ

Үнэлгээ нь тодорхой хугацааны давтамжтай стратегийн хэрэгжилтийн зорилтот үзүүлэлт, тархвар судлалын байдалд дүгнэлт өгөх явдал юм.

Хяналт-шинжилгээ үнэлгээг хийснээр:

- Стратегийн хэрэгжилт сайжирна
- Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэнд дүгнэлт өгч, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангана
- Нөөц боломжийг бүтээмжтэй, үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдэнэ

Дөрөв. Зорилго

“Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги”-ийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, бэрхшээлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх

Тав. Үндсэн зарчим

- 5.1 Үндэсний түвшинд ажилладаг хяналтын баг нь батлагдсан хуваарийн дагуу аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, МСТН-ийн салбар, Хорих 429, 461, 407-р анги, Энэрэл эмнэлэг, өрхийн эмнэлэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, бэрхшээлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.
- 5.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч эмч батлагдсан хуваарийн дагуу үйлчлэх хүрээний өрх, сумын эмнэлэг, МСТН-ийн салбарт улирал тутам хяналт хийж удирдамжийг мөрдөн ажиллаж байгаад дүгнэлт өгнө.

Зургаа. Дэмжлэгт хяналтын багийн бүрэлдэхүүн

ХӨСҮТ-ийн СТСА-ны аймаг, дүүрэг хариуцсан хяналтын болон лабораторийн эмч, халдвар судлагч, эм хариуцсан мэргэжилтэн, МСТН-ийн аймаг, дүүрэг хариуцсан ажилтан, МӨЭХ-ны ажилтнууд орно.

6.1 Хийх үйл ажиллагаа

- 6.1.1 Бүртгэл, мэдээлэл
 - Уушгины сүрьеэгийн сэжигтэй өвчтөнийг бүртгэн, шинжилгээнд илгээсэн байдалд дүгнэлт хийх

-
- Анхан шатны маягтуудын бүртгэл, мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлж тайлагнасан байдалд үнэлэлт өгөх
 - Бүртгэгдсэн тохиолдол тус бүрд эмчилгээ хяналтын карт нээж, зохих журмын дагуу хөтөлсөн байдалд хяналт тавих
 - Хяналтын шинжилгээ цаг хугацаандаа хийгдсэн байдлыг лабораторийн бүртгэлтэй тулгах
 - Сүрьеэгийн сэжигтэй хүмүүсээс цэрний түрхэц эерэг гарсан тохиолдлыг хяналтанд авч бүртгэгдсэн байдлыг лабораторийн бүртгэлээс тодруулах
 - Бүртгэлд орсон бүх өвчтөн эмчилгээнд орсон эсэхэд хяналт тавих
 - Өвчтөний эмчилгээ хяналтын картаас эмийн горим, тунг зөв тогтоосон эсэхэд хяналт тавих
 - Агуулахын эмийн хадгалалт, хүчинтэй хугацаа, нөөц эм зэргийг үзэж бүртгэгдсэн бүх өвчтөнд эм савлагдсан эсэхийг хянаж, эмчлэгдэж байгаа бүх өвчтөний 10%-д нь савлагдсан эмийг хяналтын карттай тулган зарцуулалтыг тооцох
 - Өмнөх хяналтын ажлаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах
 - Нэгжид ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнууд болон эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнүүдтэй уулзаж ярилцах

6.1.2 Лабораторийн үйл ажиллагаа

- Лаборатори нь ажлын байрны болон аюулгүй байдал, стандартыг хангасан эсэхэд дүгнэлт өгөх
- Лабораторид ашиглаж байгаа тоног төхөөрөмж, урвалж бодис нь стандартын шаардлага хангасан эсэх, боловсон хүчний хангалт, анхан шатны маягтын хөтлөлтийн байдалд хяналт хийх
- Цэрний шинжилгээг 2 сорьцоор авч, сэжигтэй 10 тохиолдол тутмаас 1 халдвартай тохиолдол илрүүлж байгааг лабораторийн бүртгэлээс шалгах
- Түрхэцийн шинжилгээг стандартын дагуу хийж байгаад хяналт тавих
- Улирал тутам хийгддэг гадаад чанарын хяналтанд түрхэцийг зохих журмын дагуу илгээж, шалгуулж байгаа эсэхийг анхан шатны маягтад үндэслэн хянах

6.1.3 Халдвар судлал, голомтын арга хэмжээ

- Бүртгэгдсэн өвчтөний сар, улирлын тайлан, тархвар судлалын үзүүлэлтүүдийг харьцуулан сүрьеэгийн өвчлөлийн байдалд дүгнэлт гаргах
- Сүрьеэтэй өвчтөний хавьтлыг үзлэгт хамруулсан байдлыг анхан шатны маягтад үндэслэн хянах
- Хавьтлын урьдчилан сэргийлэх эмчилгээг удирдамжийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих
- Сүрьеэгийн амбулатори, тасаг, лабораторийн халдвар хяналтын байдалд дүгнэлт өгч, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах

6.1.4 Дэмжлэгт хяналтын явцад дараах үйл ажиллагааг нэмж гүйцэтгэнэ.

- Эрүүл мэндийн ажилтаны ажил, үүргийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих
- Эрүүл мэндийн ажилтан, өвчтөнтэй ярилцах
- Ханган нийлүүлэлтийн байдалтай танилцаж, зөвлөмж өгөх

6.2 Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратегийн шалгуур үзүүлэлт

Дэмжлэгт хяналтын дараа нэгжүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, үнэлгээ өгнө. Үнэлгээг доорхи шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

6.2.1 Сүрьеэгийн илрүүлэлтийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Тооцоолох арга	Мэдээллийн эх үүсвэр
1. 2 сорьцоор цэрний шинжилгээ өгсөн байдал (%)	Сүрьеэгийн сэжигтэй өвчтөнөөс 2 сорьцоор цэрний шинжилгээ өгсөн тоо ----- х 100 Сүрьеэгийн сэжигтэй хэмээн шинжилгээ өгсөн бүх өвчтөний тоо	Лабораторийн бүртгэл, улирлын тайлан
2. Түрхэц эерэгийн хувь	Түрхэц эерэг гарсан уушгины сүрьеэгийн шинэ тохиолдлын тоо ----- х 100 Сүрьеэгийн сэжигтэй хэмээн шинжилгээ өгсөн бүх өвчтөний тоо	Лабораторийн бүртгэл, улирлын тайлан

3. Түрхэц эерэг тохиолдлын түвшин	Бүртгэгдсэн түрхэц эерэг уушгины сүрьеэтэй шинэ тохиолдлын тоо ----- ----- x 100 Илэрвэл зохих түрхэц эерэг уушгины сүрьеэтэй тохиолдлын тоо	Сүрьеэгийн бүртгэл, сар, улирлын тайлан
4. Түрхэц эерэг уушгины сүрьеэтэй тохиолдлын тоо 10000 хүн амд	Бүртгэгдсэн түрхэц эерэг уушгины сүрьеэтэй шинэ тохиолдлын тоо ----- ----- x 10 000 Тухайн жилийн дундаж хүн амын тоо	Сүрьеэгийн бүртгэл, сар, улирлын тайлан Хүн амын статистик тоо

6.2.2 Сүрьеэгийн эмчилгээ, хяналтын шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Тооцоолох арга	Мэдээллийн эх үүсвэр
1. Уушгины сүрьеэгийн дотор уушгины, түрхэц эерэг тохиолдлын эзлэх хувь	Уушгины түрхэц эерэг бүх тохиолдлын тоо / шинэ+дахилт / ----- ----- x 100 Уушгины сүрьеэтэй бүх тохиолдлын тоо /шинэ түрхэц эерэг+шинэ түрхэц сөрөг+дахилт/	Сүрьеэгийн бүртгэл, сар, улирлын тайлан
2. 2 (3) дахь сард сөрөгт шилжсэн түрхэц эерэг өвчтөний хувь	Эмчилгээний 2 (3) дахь сард түрхэц сөрөг болсон уушгины түрхэц эерэг тохиолдлын тоо ----- -----x 100 Түрхэц эерэг уушгины сүрьеэтэй шинэ тохиолдлын тоо	Сүрьеэгийн бүртгэл, сар, улирлын тайлан

<p>3. Бүртгэгдсэн бүх тохиолдлын эмчилгээний үр дүн</p>	<p style="text-align: center;">Эдгэрэлтийн хувь</p> <p>Эдгэрсэн тохиолдлын тоо ----- ----- х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p> <p style="text-align: center;">Эмчилгээ дуусгасан хувь</p> <p>Эмчилгээ дуусгасан тохиолдлын тоо ----- -----х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p> <p style="text-align: center;">Нас барсан хувь</p> <p>Нас барсан тохиолдлын тоо ----- ----- х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p> <p style="text-align: center;">Эмчилгээ үр дүнгүй болсон хувь</p> <p>Эмчилгээ үр дүнгүй болсон тохиолдлын тоо ----- -----х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p> <p style="text-align: center;">Эмчилгээ тасалсан хувь</p> <p>Эмчилгээ тасалсан тохиолдлын тоо ----- ----- х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p> <p style="text-align: center;">Шилжсэн хувь</p> <p>Шилжсэн тохиолдлын тоо ----- -----х 100 Бүртгэгдсэн бүх тохиолдлын тоо</p>	<p>С у р ь е э г и й н бүртгэл, сар, улирлын тайлан Эмчилгээний үр дүнгийн улирлын тайлан</p>
---	---	---

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааны удирдамж

Нэг.Үндэслэл

Хүн амд үзүүлэх анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд өрх, хувийн хэвшлийн эмнэлэг, сүрьеэгийн бус мэргэжлийн эмч, мэргэжилтнийг үе шаттайгаар оролцуулах шаардлагатай байна. Өрх, хувийн эмнэлэгт сүрьеэгийн оношлогоо, эмчилгээг хийж эхэлснээр оношийн хожимдол, эмчилгээ таслалтын хувь буурч, сүрьеэгийн илрүүлэлт, эдгэрэлтийн түвшин нэмэгдэж, улмаар сүрьеэгийн тархалт, нас баралт буурах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү удирдамжийг сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийг өргөжүүлэх үйл ажиллагаанд мөрдөнө.

Хоёр. Зорилго

ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх замаар сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги”-ийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх

Гурав.Зорилт

- 3.1 Сүрьеэгийн оношлогоо, эмчилгээний удирдамжийг төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хэрэгжүүлэх
- 3.3 Сүрьеэгийн бус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад сүрьеэгийн шууд хяналттай богино хугацааны эмчилгээний бодлогыг хэрэгжүүлснээр сүрьеэгийн илрүүлэлт, эдгэрэлтийн түвшинг нэмэгдүүлэх
- 3.4 Сүрьеэ болон сүрьеэгийн бус чиглэлээр ажилладаг эрүүл

мэндийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар сүрьеэгийн шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Дөрөв.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэр

Анагаахын ерөнхий мэргэжлийн болоод хувийн хэвшилд ажиллаж байгаа эмч, мэргэжилтнийг татан оролцуулах үндсэн хоёр хэлбэрийг ашиглана.

4.1 Төрийн эмнэлэг хоорондын түншлэл

Төрийн эмнэлэг хоорондын түншлэлийн үед аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар/ нэгдэл, салбар амбулатори, гурав дахь шатлалын эмнэлгүүд сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг харьяа сүрьеэгийн диспансерт илгээх замаар хамтарч ажиллана.

4.2 Төр, хувийн хэвшлийн эмнэлэг хоорондын түншлэл

Төр, хувийн хэвшлийн эмнэлэг хоорондын түншлэлийн хэлбэр нь сүрьеэгийн диспансер, өрхийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаа юм. Өрхийн эмнэлгийн эмч, сувилагч сүрьеэгийн сэжигтэй тохиолдлоос цэрний шинжилгээ авч, харьяа сүрьеэгийн диспансерт илгээж, онош батлагдсан тохиолдолд шууд хяналттай богино хугацааны эмчилгээг өрхийн эмнэлэг хийнэ.

Хувийн хэвшлийн үүдэн болон ортой эмнэлгээс сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг харьяа сүрьеэгийн диспансерт илгээнэ.

Тав.Удирдлага зохион байгуулалт, хамрах хүрээ

- 5.1 Эрүүл Мэндийн Яамны дэргэд сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлж, удирдан зохион байгуулах, хяналт үнэлгээ хийх үүрэг бүхий Үндэсний Зохицуулах Баг (ҮЗБ) байгуулагдан ажиллана.
- 5.2 Дүүрэгт энэхүү ажлыг зохион байгуулах зохицуулах баг байгуулагдана.

Зургаа.Хэрэгжүүлэх арга зам

- 6.1 Төр хувийн хэвшлийн түншлэлийг сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд нэвтрүүлэх туршилтын үе. Улаанбаатар

хотын 2 дүүрэгт байрлах бүх өрхийн эмнэлэг, уушгины чиглэлээр ажилладаг хувийн эмнэлэг, хоёр, гурав дахь шатлалын улсын эмнэлгүүд хамрагдах бөгөөд ЭМЯ, Монголын Өрхийн Эмнэлгүүдийн Холбоо, Монголын Хувийн Хэвшлийн Эрүүл Мэндийн Байгууллагын Нэгдсэн Холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэж, тусгагдсан үүргийг гүйцэтгэнэ.

- 6.2 Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үе Аймаг, дүүргийг үе шаттайгаар хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ.

Долоо.Оролцогч талуудын бүрэлдэхүүн, үүрэг

7.1 Үндэсний зохицуулах багийн бүрэлдэхүүн

Дарга: ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Оролцогч дарга: ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

Нарийн бичгийн дарга: ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн
- Улсын мэргэжлийн хяналтын газрын эрүүл мэндийн албаны дарга
- ДЭМБ-ын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (тохиролцсоноор)
- Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн

-
- сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
 - Монголын өрхийн эмнэлгүүдийн холбооны гүйцэтгэх захирал
 - Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал
 - Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн (тохиролцсоноор)

7.2 Үндэсний зохицуулах багийн үүрэг

- 7.2.1 Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэхэд талуудыг татан оролцуулж, удирдан зохион байгуулна.
- 7.2.2 Сүрьеэгийн эм, цэрний сорьц цуглуулах, тээвэрлэх сав, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, бүртгэл мэдээллийн маягтаар хангана.
- 7.2.3 Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэхэд оролцох эмч, эмнэлгийн ажилчдыг сургалтанд хамруулна.
- 7.2.4 Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийнэ.
- 7.2.5 Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд ТХХТ-ийн талаар баримтлах бодлого тодорхойлох, шийдвэр гаргах, тулгамдаж буй асуудлыг зохицуулах зорилгоор улирал тутамд хуралдана.
- 7.2.6 ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталж, хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавина.
- 7.2.7 ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагааг сурталчилахад дэмжлэг үзүүлнэ.
- 7.2.8 ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийнэ.
- 7.2.9 Үндэсний хэмжээнд сүрьеэгийн илрүүлэлтийн түвшинг нэмэгдүүлэхэд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсан төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнийг шалгаруулан, урамшуулна.

7.3 Аймаг, дүүргийн зохицуулах багийн бүрэлдэхүүн, үүрэг

Дарга: Аймаг, дүүргийн ЗДТГ-ын эрүүл мэндийн асуудал хариуцсан түшмэл

Орлогч дарга: Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга/орлогч дарга

Нарийн бичгийн дарга: Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн зохицуулагч эмч

Гишүүд:

- Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн өрхийн эмнэлэг хариуцсан мэргэжилтэн
- Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн халдвар судлаач эмч
- Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын албаны эмнэлгийн тусламж хариуцсан байцаагч
- Хувийн хэвшлийн эмнэлгийн төлөөлөл
- Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын аймаг, дүүргийн төлөөлөл (тохиролцсоноор)
- Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн аймаг, дүүргийн зохицуулагч
- Аймаг, дүүргийн өрхийн эмнэлгүүдийн холбооны салбар зөвлөлийн дарга

7.4 Аймаг, дүүргийн зохицуулах багийн үүрэг

- 7.4.1 Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагааны дүүргийн төлөвлөгөө, төсвийг баталж, хэрэгжилт, зарцуулалтыг хянана.
- 7.4.2 Аймаг, дүүргийн хэмжээнд ТХХТ-ийг өргөжүүлэх үйл ажиллагаатай холбоотой тулгарч буй асуудлыг зохицуулах зорилгоор улирал тутам уулзалт зохион байгуулна.
- 7.4.3 Аймаг, дүүргийн хэмжээнд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ хийж, Үндэсний зохицуулах багтай хамтран үнэлнэ.
- 7.4.4 Аймаг, дүүргийн хэмжээнд сүрьеэгийн илрүүлэлт, эдгэрэлтийн түвшинг стратегийн шалгуур үзүүлэлтэд хүргэсэн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтэнг шалгаруулж, Үндэсний зохицуулах багт танилцуулж, урамшуулна.

7.5 Төр, хувийн хэвшлийн түншлэлд оролцогч талуудын хүлээх үүрэг, оролцоо

Шууд хяналттай богино хугацааны эмчилгээний бүрэлдэхүүн хэсэг	Сүрьеэгийн диспансер	Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Өрх, сумын эмнэлэг
1. Удирдлагын дэмжлэг	√	√	√	√
2. Сургалт, ухуулга сурталчилгаа	√	√	√	√
3.Цэрний түрхэцийн шинжилгээ* / сорьц зөөх	√	√	√	√
4.Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ	√			√
5. Эмийн тасралтгүй хангамж	√			√
6. Бүртгэл, мэдээлэл, тайлан	√	√	√	√
7.Өвчтөн илгээх		√	√	√
8.Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ хийх	√			√

* Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангагдсан, сургагдсан мэргэжилтэнтэй нэгж хийж болно.

7.6 Монголын өрхийн эмнэлгийн холбооны үүрэг

Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд ТХХТ-ийг нэвтрүүлэн өргөжүүлэхэд Монголын өрхийн эмнэлгүүдийн холбоо дараах үүргийг гүйцэтгэнэ:

- 7.6.1 Харилцан Ойлголцлын Санамж Бичигт заасан үүрэг хариуцлагыг биелүүлж, сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг өрхийн эмнэлгийн хүрээнд удирдан зохион байгуулна.
- 7.6.2 Сургалт, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
- 7.6.3 Сорьц зөөвөрлөлтийн үйл ажиллагааг зохицуулж санхүүгийн нөөцийг зохистой хуваарилна.
- 7.6.4 Өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд явцын хяналт тавьж,

тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлыг Үндэсний зохицуулах багт танилцуулж шийдвэрлүүлнэ.

- 7.6.5 Хамрагдсан өрхийн эмнэлгээс сар бүр тайлан мэдээ авч нэгтгэн, удирдамжийн хэрэгжилтийг улирал тутамд Үндэсний зохицуулах багт тайлагнана.

7.7 Монголын Хувийн Хэвшлийн Эрүүл Мэндийн Байгууллагын Нэгдсэн Холбооны үүрэг, хариуцлага

- 7.7.1 Харилцан Ойлголцлын Санамж Бичигт заасан үүрэг хариуцлагыг биелүүлж хувийн эмнэлгийн хүрээнд удирдан зохион байгуулна.
- 7.7.2 Хувийн хэвшлийн эмч, эмнэлгийн ажилтаныг сургах, хүн амд ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
- 7.7.3 Хамрагдсан хувийн эмнэлгийн үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, тулгамдсан бэрхшээлтэй асуудлыг Үндэсний зохицуулах багт танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 7.7.4 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааны удирдамжийн хэрэгжилтийг улирал тутамд Үндэсний зохицуулах багт тайлагнана.

7.8. Өрхийн эмнэлгийн үүрэг

- 7.8.1 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчээс цэрний сорьц авч, онош тодруулахаар харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт илгээнэ.
- 7.8.2 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг илгээсэн болон шинжилгээнд хамруулсан тохиолдлыг “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл” -д бүртгэж аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт “Өвчтөн илгээх хуудас”-аар тухай бүр мэдээлнэ.
- 7.8.3 Сүрьеэтэй нь оношлогдсон үйлчлүүлэгчийг удирдамжийн дагуу шууд хяналттай эмчилж, “Сүрьеэтэй өвчтөнүүдийн эмчилгээ хяналтын бүртгэл”, “Эмчилгээний хяналтын карт” хөтөлнө.
- 7.8.4 Хяналттай эмчлүүлэгчийн сүрьеэгийн эмийг аймаг, дүүргийн диспансераас авч эмийн захиалга, тээвэрлэлт, хадгалалт, зарцуулалт зэргийг удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 7.8.5 Эмчилгээний хяналтын шинжилгээний сорьцыг хугацаанд нь цуглуулж сүрьеэгийн диспансерт илгээж хариуг авна.

-
-
- 7.8.6 Голомтын судалгаа хийж гэр бүлийн хавьтлыг шинжилгээнд бүрэн хамруулан “Сүрьеэтэй өвчтөний хавьтлын бүртгэл, хяналт” хөтөлнө.
 - 7.8.7 Сүрьеэ өвчний талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, өвчлөх эрсдэлтэй хүн амын дунд сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг хийнэ.
 - 7.8.8 Өрхийн эмнэлгээр үзүүлж буй сүрьеэгийн тусламж, үйлчилгээний нэгтгэсэн тайлан, өрхийн эмнэлгийн сорьц зөөвөрлөлтийн тайлан гаргаж аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт сар, улирал тутам мэдээлнэ.
 - 7.8.9 Гурвалсан гэрээнд заасан үүрэг хариуцлагыг мөрдөн биелүүлнэ.

7.9 Хувийн эмнэлгийн үүрэг

- 7.9.1 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл”-д бүртгэж харьяа өрхийн эмнэлэг, сүрьеэгийн диспансерт илгээнэ.
- 7.9.2 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг илгээсэн тохиолдлыг аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт “Өвчтөн илгээх хуудас” -аар мэдээлнэ.
- 7.9.3 Сүрьеэ өвчний талаар сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.
- 7.9.4 “Хувийн хэвшлийн эмнэлэг, ЭМН-ийн салбар амбулатори, 3 дахь шатлалын эмнэлгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан” гаргаж СТСА-нд сар, улирал тутам мэдээлнэ.

7.10 ХӨСҮТ-ээс бусад Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн үүрэг

- 7.10.1 Уушгины сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл”-д бүртгэнэ.
- 7.10.2 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчээс цэрний сорьц авч өөрийн лабораторид оношлож, түрхэцийг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээж баталгаажуулна. Цэрний түрхэцийн шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд үйлчлүүлэгч эсвэл сорьцыг харьяа сүрьеэгийн диспансерт, орон нутгийн үйлчлүүлэгчийг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны үзлэгийн кабинет, сорьцыг сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээнэ.
- 7.10.3 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг илгээсэн

болон шинжилгээнд хамруулсан тохиолдлыг үйлчлүүлэгчийн харьяа сүрьеэгийн диспансерт “Өвчтөн илгээх хуудас”-аар мэдээлнэ.

- 7.10.4 Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэ оношлогдсон тохиолдолд удирдамжийн дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэхээр шилжүүлнэ.
- 7.10.5 “Хувийн хэвшлийн эмнэлэг, ЭМН-ийн салбар амбулатори, 3 дахь шатлалын эмнэлгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан” гаргаж СТСА-нд сар, улирал тутам мэдээлнэ.

7.11 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, салбар амбулаторийн үүрэг

- 7.11.1 Уушгины сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл”-д бүртгэн аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт “Өвчтөн илгээх хуудас”-аар мэдээлнэ.
- 7.11.2 Уушгины түрхэц сөрөг болон уушгины бус эрхтэний сүрьеэгийн онош эргэлзээтэй тохиолдолд оношлогоо, эмчилгээний асуудлыг аймаг, дүүргийн эмч нарын зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.
- 7.11.3 “Хувийн хэвшлийн эмнэлэг, ЭМН-ийн салбар амбулатори, 3 дахь шатлалын эмнэлгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан” гаргаж СТСА-нд сар, улирал тутам мэдээлнэ.

7.12 Сүрьеэгийн диспансерийн үүрэг

- 7.12.1 Өрх, хувийн эмнэлэг, бусад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчээс илгээсэн болон өөрөө ирж үйлчлүүлж буй сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгчийг үзлэг шинжилгээнд хамруулан онош тодруулна.
- 7.12.2 Сүрьеэтэй нь оношлогдсон үйлчлүүлэгчийг удирдамжийн дагуу харьяа өрхийн эмнэлэг, ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникт шилжүүлэх эсвэл диспансерт шууд хяналттай эмчилнэ.
- 7.12.3 Өрхийн эмнэлгээр үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хяналт тавьж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.
- 7.12.4 Өрхийн эмнэлэг, сүрьеэгийн диспансерт эмчлүүлэгчийг

сүрьеэгийн эмээр тасралтгүй хангаж, эмийн захиалга, тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, зарцуулалтыг удирдамжийн дагуу зохион байгуулна.

7.12.5 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний нэгтгэсэн тайланг ХӨСҮТ–ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд улирал тутам мэдээлнэ.

7.12.6 Удирдамжийн хэрэгжилтийг хянан, аймаг, дүүргийн зохицуулах багтай хамтран үнэлгээ хийнэ.

7.13 Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэгийн үүрэг

7.13.1 Сүрьеэтэй эмчлүүлэгчийн эмийг гэрт нь хүргэж, шууд хяналттай уулгах эсвэл хоолтой эмчилгээнд хамруулна.

7.13.2 Сайн дурын идэвхтэнээр дамжуулан сүрьеэтэй эмчлүүлэгчийн хяналтын шинжилгээг хугацаанд нь бүрэн хийлгэж, хавьтлыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулна.

7.13.3 Эмчлүүлэгч, тэдний гэр бүлд сүрьеэгийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийнэ.

Найм. Түрхэц сөрөг уушгины сүрьеэ болон уушгины бус эрхтэний сүрьеэг оношлох эмч нарын зөвлөгөөн

8.1 Үндэслэл

Уушгины түрхэц сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэг эрт оношлохын тулд нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг, шинжилгээ хийж шийдвэрлэнэ.

Эмч нарын зөвлөгөөнийг аймгийн түвшинд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотод дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд түшиглэн зохион байгуулна.

8.2 Аймаг, дүүргийн эмч нарын зөвлөгөөний бүрэлдэхүүн

Эмч нарын зөвлөгөөнийг аймаг дүүргийн ЭМГ/Нэгдсэн эмнэлэг, ЭМН-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга удирдана. Гишүүдэд нь төрийн болон хувийн эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн эмч нарыг оролцуулж болно. Эмч нарын зөвлөгөөнд оролцох гишүүдийг Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн нэгдлийн даргын тушаалаар батална.

Дарга- эмнэлгийн тусламж хариуцсан орлогч дарга

Нарийн бичиг- аймаг дүүргийн сүрьеэгийн зохицуулагч эмч

Гишүүд – аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч, дотрын эмч, мэс заслын эмч, гэрлийн эмч, эмгэг судлаач эмч, хүүхэд, эмэгтэйчүүдийн эмч шаардлагатай бол бусад мэргэжлийн эмч

8.3 Үүрэг

- 8.3.1 Өрх, сумын эмнэлгээс ирүүлсэн сүрьеэгийн сэжигтэй тохиолдлын оношлогоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.
- 8.3.2 Шаардлагатай тохиолдолд дээд шатлалын нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна.
- 8.3.3 Уушгины түрхэц сөрөг болон уушгины бус хэлбэрийн сүрьеэгийн оношийг эд эс, бактериологийн шинжилгээгээр баталгаажуулна.
- 8.3.4 Эмч нарын зөвлөгөөнийг тухайн орон нутгийн өвчлөлөөс хамаарч сард нэгээс доошгүй удаа, яаралтай шийдвэрлэх шаардлагатай үйлчлүүлэгчийн хувьд хугацаа харгалзахгүй шуурхай зөвлөгөөн хийнэ.

Улс, хувийн хэвшлийн эмнэлгийн гүйцэтгэх үүрэг, оролцоо

ДОТС-ын бүрэлдэхүүн хэсэг	Сүрьеэгийн диспансер	Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Өрх, сумын эмнэлэг
1. Удирдлагын дэмжлэг	√	√	√	√
2. Тохиолдлыг оношлох				
Эмнэлзүйн үнэлгээ	√	√	√	√
Цэрний түрхэцийн шинжилгээ	√	√		√
Цээжний гэрлийн шинжилгээ	√	√		
3. Тохиолдлыг эмчлэх				
Шууд хяналттай богино хугацааны эмчилгээний хяналт	√			√
Цэрний сорьцын чанарын хяналт	√	√		√

Удирдамжийн дагуу өвчтөн шилжүүлэх	√	√		√
Эмнэлзүйн хяналт	√			√
Эмчилгээ тасалдсан тохиолдлыг эргэн эмчилгээнд хамруулах	√			√
4. Эмийн тасралтгүй хангамж	√			√
5. Бүртгэл, мэдээлэл, тайлан, хяналт-шинжилгээ				
Уушигны эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл		√	√	√
Өвчтөн илгээх хуудас		√	√	√
Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын бүртгэл		√	√	√
Эмчилгээний хяналтын карт	√			√
Сүрьеэтэй өвчтөний хавьтлын бүртгэл, хяналт	√			√
Өрхийн эмнэлгээр үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан				√
Өрхийн эмнэлгийн сорьц зөөвөрлөлтийн тайлан				√
Хувийн хэвшлийн эмнэлэг, ЭМН-ийн салбар амбулатори, 3 дахь шатлалын эмнэлгийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан		√	√	
Диспансерт үзүүлж буй сүрьеэгийн тусламж үйлчилгээний тайлан	√			
Өвчтөн илгээх		√	√	√

Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааны удирдамжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, дэмжлэгт хяналтыг улирал тутам, үнэлгээг жилд нэг удаа хийнэ.

9.1 Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт

1	Сургалтанд хамрагдсан эмчийн тоо
2	Сүрьеэгийн сэжигтэй үйлчлүүлэгч эсвэл сорьцыг диспансерт илгээж байгаа эрүүл мэндийн байгууллагын тоо
3	ТХХТ-ийг хэрэгжүүлэгч нэгж (өрхийн эмнэлэг, хувийн эмнэлэг)-ийн тоо
4	Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан нэгжийн тоо

9.2 Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

1. Тохиолдлын илрүүлэлт		
	Үзүүлэлт	Тооцоолох арга, тайлбар
1.1	Диспансерт илгээсэн үйлчлүүлэгч, сорьцын тоо	Нэгж бүрээр гаргах (өрхийн эмнэлэг, хувийн эмнэлэг, 3 дахь шатлалын эмнэлэг, салбар амбулатори)
1.2	Үүнээс:Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй илэрсэн өвчтөний тоо, хувь	Нэгжээс илэрсэн түрхэц эерэг тохиолдлын тоо ----- -----x 100 Илгээсэн бүх тохиолдлын тоо
1.3	Илрүүлсэн шинэ уушгины түрхэц эерэг тохиолдлын эзлэх хувь	ТХХТ-ийг хэрэгжүүлэгчдийн шинээр илрүүлсэн уушгины түрхэц эерэг тохиолдлын тоо ----- ----- x 100 Улсын хэмжээнд шинээр илэрсэн уушгины түрхэц эерэг тохиолдлын тоо
2. Эмчилгээний үр дүн (өрхийн эмнэлэг)		
2.1	Хяналттай эмчилгээ хийлгэж буй өвчтөний эзлэх хувь	Хяналттай эмчилгээ хийлгэж буй өвчтөний тоо ----- ----- x 100 Улсын хэмжээнд сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөний тоо

2.2	Хяналттай эмчилгээ хийлгэж эдгэрсэн, эмчилгээ дуусгасан, үр дүнгүй эмчлэгдсэн, эмчилгээ тасалсан, шилжсэн, нас барсан уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэгийн эзлэх хувь	Эдгэрсэн уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэгийн тохиолдлын тоо ----- x100 Нийт уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэгийн тохиолдлын тоо Эмчилгээний үр дүнгийн үзүүлэлт бүрээр гаргана
-----	---	--

Арав. Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах арга зам

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг тогтвортой хангахад эдийн засгийн болон бусад хөшүүргийг хэрэглэнэ.

Эрүүл мэндийн нэгдэл, Монголын өрхийн эмнэлгүүдийн холбоо, өрхийн эмнэлэг гурвалсан гэрээ байгуулан ажиллаж, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж сайн ажилласан өрхийн эмнэлэг, эмч, эмнэлгийн ажилтанг шалгаруулж, аймаг, дүүргийн засаг даргын тамгын газраас урамшуулна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны сарын...
өдрийн тоот тушаалаар батлав.
ТХТ-1

УУШИГНЫ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ИЛРҮҮЛЭХ БҮРТЭЛ

№	Эцэг(эх)-ийн нэр, Нэр	Нас, хүйс	Тогтмол хаяг	Ажлын газар	Түрхэцийн шинжилгээ			Цэвэрийн зургийн шинжилгээ		Туберку-лины сорил		Онош	Тайлбар			
					Шинжилгээ өгсөн огноо	I	II	Явуулсан	Авахуулсан	Шинжилгээний хариу	Сорил тавьсан огноо			Сорилын үр дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
						Шинжилгээнд явуулсан огноо						Шинжилгээний хариу				

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 сарын
20 өдрийн 397 тоот тушаалаар батлав.

ТХТ-2

ӨВЧТӨН ИЛГЭЭХ ХУУДАС

Эмнэлгийн нэр _____

--	--	--	--	--	--

Өвчтөний эцэг/эх/-ийн нэр, Нэр _____

РД _____

Нас _____

Хүйс: Эрэгтэй, Эмэгтэй

Тогтмол хаяг _____

Утасны дугаар _____

Заалт: () Цэрний шинжилгээ

() Шууд хяналттай эмчилгээ

() Бусад _____

Илгээх байгууллагын нэр _____

Эмчийн гарын үсэг _____ / _____ /

Он _____ сар _____ өдөр

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 сарын
20 өдрийн 397 тоот тушаалаар батлав.
ТХТ-3

СҮРЬЭТЭЙ ӨВЧТӨНҮҮДИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН БҮРТГЭЛ

Сар өдөр	№	Эцэг(эх)-ийн нэр, нэр	Нас, Тогмол хүйс хаяг	Ажлын газар	Онош	Анх оношилсон эрүүл мэндийн байгууллага	Эмчилгээний хамрагдалт		11	12	13	14	15	16	17	18	19	
							Эмчилгээнд орсон сар өдөр	Эмчилгээний бүлэг, горим										
							Анх	Давтан				Эдгэрсэн	Эмчлгээ дууссан	Үрдүнгийн эмчлэгдсэн	Эмчлгээ тасалсан	Шилжсэн	Нас барсан	Тайлбар

Өрхийн эмнэлгийн нэр:

Өрхийн эмчийн нэр:

Он:

ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН КАРТ

Өрхийн эмнэлгийн нэр _____ Нэр _____
 Өвчтөний эцэг (эх)-ийн нэр _____
 Тогтмол хаяг _____
 Онош _____

Нян илрэлтийн байдал:

Цэргий шинжилгээ			
О сар	2 сар	3 сар	5 сар
			6 сар
			8 сар

Эмчилгээний эрчимт шатанд эм өгсөн тэмдэглэгээ:

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
Өдөр																																
Гарын үсэг																																
Сар																																
Өдөр																																
Гарын үсэг																																

Маягтын ар тал

Эмчилгээний үргэлжлэх шатанд эм өгсөн тэмдэглэгээ:

Сар																																
Өдөр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
Гарын үсэг																																
Сар																																
Өдөр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
Гарын үсэг																																
Сар																																
Өдөр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
Гарын үсэг																																
Сар																																
Өдөр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
Гарын үсэг																																

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 сарын
20 өдрийн 397 тоот тушаалаар батлав.
ТХТ-5

СҮРЬЭТЭЙ ӨВЧТӨНИЙ ХАВЬТЛЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

Өрхийн эмнэлгийн нэр..... Өрхийн эмчийн нэр.....

Сар өдөр	№	Эцэг(эх)-ийн нэр, нэр	Нас, хүйс	Гэрийн хаяг	Онош, бүлэг	Хавьтлын урьдчилан сэргийлэлт											Онош	Тайлбар	
						7	8	9	10	11	12	13	14	15	16	17			18
1	2					Хавьтлын тоо	Хавьтлын нэрс	Өвчтөний хэсэг болох	Түрхцийн шинжилгээнд явуулсан огноо	Түрхцийн шинжилгээ хийгээсэн огноо	Түрхцийн шинжилгээний хариу	Цэжний зураг авахуулахаар илгээсэн огноо	Цэжний зураг авахуулсан огноо	Цэжний зургийн шинжилгээний хариу	Түбэргүлний сорил тавигдсан огноо	Түбэргүлний сорил шалтсан огноо	Түбэргүлний сорилын дүн	19	20

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 сарын
20 өдрийн 397 тоот тушаалаар батлав.
ТХТ-7

ӨРХИЙН ЭМНЭЛГЭЭР ҮЗҮҮЛЖ БҮЙ СҮРБЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН

Аймаг/дүүрэг _____ Өрхийн эмнэлгийн нэр _____

Үлгэрлэл	Сурьбагийн илрүүлэлт				Сорьц тэвэрлэлт		Урьдчилан сэргийлэлт				Мэдээлэл сургалт, сурталчилгаа							
	Цэвэрлэгдсэн Хамрагдсан	Цэвэрлэгдсэн Хамрагдсан	Илэрсэн нийт тохиолдлын тоо	Сэжигтэй тохиолдлын тоо	Цэвэрлэсэн давтамж тоо	Зөвөвлөсөн сорьцын тоо	Үнсээс: Хавьтлын үзэлт хамрагдсан хүний тоо	БЦЖ вакцины сорвийг үнэлсэн хүүхдийн тоо	Нөхөн дархлаа- жуулалтад хамрагдсан хүүхдийн тоо	Сургалтын тоо	Хамрагдсан хүний тоо	Сурталчлалганы тоо	Хамрагдсан хүний тоо	Сурталчлалганы тоо	Хамрагдсан хүний тоо			
1																		
I																		
II																		
III																		
IV																		
БҮГД																		

Тэмдэг Тайланг нэгтгэсэн: Эмч _____ /

Он сар өдөр

ӨРХИЙН ЭМНЭЛЭГИЙН СОРЬЦ ЗӨӨВӨРЛӨЛТИЙН ТАМЛАН

Өрхийн эмнэлгийн нэр

Д/д	сар өдөр	Шинжилгээнд хамрагдагсдын эцэг(эх)-ийн нэр, Нэр	нас хүйс	Шинжилгээний зорилго		Сорьц				Шинжилгээний хариу	
				ОНОШЛОГОО	ХЯНАЛТ	Авсан ОГНОО	Тэвэвлэсэн ОГНОО	ТОО	чанар	I	II
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Тайлан гаргасан...../өрхийн эмч/

Он сар өдөр